

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-65-Р ДҮРМИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center">ИНД-65 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх, зэрэглэл (Шинэчлэгдэж байгаа) /26 хуудас/ 2015 оны NZ amend.5</p>	<p align="center">ИНД-65 Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтны үнэмлэх зэрэглэл (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) / 18 хуудас (үндсэн дүрэм-44 хуудастай байсан)/1997 оны NZ original</p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг - Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>65.1 Хамрах хүрээ Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) НХҮ-ний ажилтны үнэмлэх болон зэрэглэл олгох; (2) тухайн үнэмлэх, зэрэглэл шаардлагатай нөхцөл; (3) тухайн үнэмлэх, зэрэглэлийн эрх, хязгаарлалт</p>	<p>65.1. Зорилго (а) Энэ дүрмийн зорилго нь нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (цаашид НХҮ гэх)-ний ажилтанд мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл олгоход тавигдах шаардлага болон уг үнэмлэх, зэрэглэлийн хүрээнд эдлэх эрх, хязгаарлалтыг тогтооход оршино.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>65.3 Нэр томъёо ба товчлол Энэ Дүрэмтэй холбоотой нэр томъёо болон товчлол нь ИНД-ийн нэр томъёоны тайлбарт багтсан.</p>	<p>65.3. Тодорхойлолт</p>	<p>- Нэр томъёоны тайлбар, тодорхойлолтууд ИНД-1-д орсон.</p>
<p>65.5 Үнэмлэх зэрэглэлийн шаардлага (а) ИНД-172.1-д заасан агаарын зайд НХҮ үзүүлэх этгээд нь тухайн үйлчилгээг зөвхөн ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээний дагуу үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагын эрхийн хүрээнд үзүүлж болох ба дараах үнэмлэх, зэрэглэл эзэмшдэг байх үүрэгтэй: (1) энэ Дүрмийн дагуу олгосон хүчинтэй НХҮ-ний ажилтны үнэмлэх; (2) энэ Дүрмийн дагуу олгосон бөгөөд зөвшөөрсөн хүчинтэй зэрэглэл. (б) Энэ дүрмийн 65.405-д заасан НХҮ-ний багшийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд нь энэ Дүрмийн дагуу олгосон хүчинтэй НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшдэг байх үүрэгтэй. (с) Энэ дүрмийн 65.455-д заасан НХҮ-ний шалгагчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд нь энэ Дүрмийн дагуу олгосон хүчинтэй НХҮ-ний шалгагчийн зэрэглэл эзэмшдэг байх үүрэгтэй.</p>	<p>65.5. Ерөнхий шаардлага (а) <u>Нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээнд оролцох аливаа этгээд энэ дүрмийн дагуу олгосон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний хүчин төгөлдөр үнэмлэх, зэрэглэлтэй байна.</u> (б) НХҮ-ний ажилтанд багшлах этгээд нь энэ дүрмийн И бүлэгт заасан хүчин төгөлдөр багшлах зэрэглэлтэй байна. (в) НХҮ-ний ажилтныг шалгах этгээд нь энэ дүрмийн К бүлэгт заасан, хүчин төгөлдөр шалгах зэрэглэлтэй байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

65.7 Үнэмлэх, зэрэглэл

(а) Дарга, энэ Дүрмийн холбогдох шаардлагын дагуу, НХҮ-ний ажилтны дараах үнэмлэх болон зэрэглэл олгож болно:

- (1) сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх;
- (2) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх;
- (3) сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх;
- (4) нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх;

(5) нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл;

- (6) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн дараах зэрэглэл:
 - (i) аэродромын удирдлагын зэрэглэл;
 - (ii) ойртолтын процедур-удирдлагын зэрэглэл;
 - (iii) ойртолтын ажиглалтын-удирдлагын зэрэглэл;
 - (iv) бүсийн процедур-удирдлагын зэрэглэл;
 - (v) бүсийн ажиглалтын-удирдлагын зэрэглэл;
- (7) нислэгийн мэдээллийн ажилтны дараах зэрэглэл:
 - (i) хамааралгүй;
 - (ii) аэродромын нислэгийн мэдээллийн зэрэглэл;
 - (iii) бүсийн нислэгийн мэдээллийн зэрэглэл;
- (8) НХҮ-ний Багшийн зэрэглэл;
- (9) НХҮ-ний Шалгагчийн зэрэглэл.

(b) НХҮ-ний багшийн болон НХҮ-ний шалгагчийн зэрэглэлийг тухайн эзэмшигчийн үнэмлэхэнд тэмдэглэсэн байх ёстой.

(c) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад зэрэглэл болон энэ Дүрмийн дагуу НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшигчид олгосон зөвшөөрлийг тухайн үнэмлэх эзэмшигчийн НХҮ-ний ажилтны бүртгэлийн дэвтэрт тэмдэглэсэн байх ёстой

65.7. Үнэмлэх ба зэрэглэл

(а) Энэ дүрмээр дараах ангиллын үнэмлэх олгож, зэрэглэл тогтооно:

1/ Үнэмлэх:

- 1.1. Нислэгийн удирдагч (цаашид НУ гэх)-ийн;
- 1.2. Нислэгийн мэдээллийн ажилтан (цаашид НМА гэх)-ны;
- 1.3. Сурагч нислэгийн удирдагчийн;

2/ Зэрэглэл:

2.1. Нислэгийн удирдагчийн:

- 2.1.1. Аэродромын нислэгийн удирдлагын;
- 2.1.2. Ойртолтын нислэгийн удирдлагын;
- 2.1.3. Бүсийн нислэгийн удирдлагын;
- 2.1.4. Ойртолтын ажиглалтын удирдлагын
- 2.1.5. **Нарийвчлалттай ойртолтын ажиглалтын удирдлагын;**
- 2.1.6. Бүсийн ажиглалтын удирдлагын;

2.2. Нислэгийн мэдээллийн ажилтны:

- 2.2.1. Аэродромын нислэгийн;
- 2.2.2. Бүсийн нислэгийн;

2.3. НХҮ-ний багшлах;

- 2.3.1. Аэродромын; /НМА/
- 2.3.2. Ойртолтын;
- 2.3.3. Бүсийн;

2.3.4. Ажиглалтын удирдлагын; /Бүсийн, Ойртолтын/

2.4. НХҮ-ний шалгах;

- 2.4.1. Ажлын байрны;
- 2.4.2. Дадлагажуурын байрны;

(б) НХҮ-ний ажилтны үнэмлэхэнд зэрэглэл, түүний хүчинтэй хугацааг заасан байна.

(в) Энэ дүрмийн дагуу олгосон үнэмлэхийг Чикагогийн конвенцийн аль нэг хэлэлцэн тохирогч улсад хүлээн зөвшөөрөх боломжтой гэдгийг Иргэний нисэхийн ерөнхий газар /ИНЕГ/-ын дарга бататгана.

(г) ИНЕГ-ын дарга нь Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч аль нэг улсаас олгосон хүчин төгөлдөр үнэмлэхийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тухайн

-орчуулга,
найруулга зассан

-радио-холбооны
операторын
зэрэглэл өгдөггүй
байсан

ба үнэмлэхэнд нь бичиж болно.	үнэмлэх эзэмшигчийг үнэмлэхний дагуу ажил үүрэг гүйцэтгүүлэх бол энэ дүрмийн Ж бүлгийн шаардлага хангасан байна.	
65.9 Нөөц		
65.11 Үнэмлэх, зэрэглэл эзэмших хүсэлт гаргах НХҮ-ний ажилтны үнэмлэх, НХҮ-ний багшийн зэрэглэл, эсхүл НХҮ-ний шалгагчийн зэрэглэл эзэмших, эсхүл тухайн үнэмлэхний бусад зэрэглэлийн баталгаажуулсан тэмдэглэл хийлгэх хүсэлт гаргагч нь САА 24065/01 маягтыг бөглөж, зохих төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлнэ.	65.11. Өргөдөл гаргах (а) Энэ дүрмийн дагуу үнэмлэх, зэрэглэл авах , өргөдөл гаргаж буй аливаа этгээд (цаашид Өргөдөл гаргагч гэх) нь ИНЕГ-002 маягт “тохирох зөв хүн” /fit and proper person/-д тавигдах шаардлага болон ИНЕГ- 065/01 өргөдлийн маягтыг; (б) Зэрэглэлийг баталгаажуулахаар өргөдөл гаргагч нь ИНЕГ-065/02 маягтыг, бөглөж төлбөрийн баримтын хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ.	-Орчуулга, найруулга зассан
65.13 Үнэмлэх, зэрэглэл олгох Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь энэ Дүрмийн дагуу үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмших эрхтэй: (1) хүсэлт гаргагч нь тохирох зөв хүн байх; (2) хүсэлт гаргагч нь тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн дагуу үүрэг гүйцэтгэхэд шаардагдах монгол болон англи хэлээр унших, бичих, ярих, ойлгох чадвартай байх; (3) хүсэлт гаргагч нь тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэл олгохтой холбоотой энэ Дүрэмд заасан бүх нөхцөл хангах шаардлагыг хангасан байх; (4) тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэлийг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.	65.13. Үнэмлэх, зэрэглэл олгоход тавигдах ерөнхий шаардлага (а) ИНЕГ-ын дарга нь дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид энэ дүрмийн дагуу үнэмлэх, зэрэглэл олгоно. Үүнд: 1/ ИНЕГ-002 маягтад тавигдах шаардлагад нийцсэн байх; 2/ үнэмлэх, зэрэглэлийн дагуу үүрэг гүйцэтгэхэд шаардагдах хэл (монгол, англи)-ээр унших, бичих, ярих, ойлгох чадвартай; 3/ үнэмлэх, зэрэглэл олгохтой холбогдсон, энэ дүрэмд заагдсан бусад шаардлагуудыг хангасан; 4/ үнэмлэх, зэрэглэл олгосноор нисэхийн аюулгүй ажиллагаанд харшлахгүй байх.	-Орчуулга, найруулга зассан
65.15 Үнэмлэх, зэрэглэлийн хугацаа (а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд, энэ Дүрмийн дагуу олгосон үнэмлэх, эсхүл зэрэглэлийг Хуулийн дагуу түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгоогүй бол тухайн эзэмшигчийн насан туршид хүчинтэй байна. (б) Дарга шаардлагатай гэж үзсэн тохиолдолд түр үнэмлэх, эсхүл зэрэглэл олгож болно.	65.15. Үнэмлэх, зэрэглэлийн хүчин төгөлдөр байдал (а) НХҮ-ний ажилтны үнэмлэх нь үйлчлэлийг нь түдгэлзүүлсэн, хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчин төгөлдөр байна. <p style="text-align: center;">2001 онд орхигдуулсан</p>	-Орчуулга, найруулга зассан
65.17 Шалгалт	65.17. Шалгалт	-Шалгалтын 80%-г

<p>(a) Энэ Дүрмийн дагуу бичгийн шалгалт өгөх <u>этгээд нь</u>: (1) өөрийгөө нотлох баримт бичгийг биедээ авч явах; (2) өндөр босго үнэлгээ шаардсанаас бусад шалгалтад тэнцэхийн тулд боломжит үнэлгээний <u>70%-иас</u> доошгүйг авсан байна.</p> <p>(b) Энэ Дүрмээр шаардсан <u>шалгалт авч байгаа байгууллага</u> нь шалгалт өгсөн этгээдийн <u>хангалтгүй мэдлэгийн зөрүүг тодорхойлох</u> ба шалгалтад тэнцсэн дүгнэлт гаргахаас өмнө эдгээр мэдлэгийн зөрүүг арилгасныг бататгана.</p>	<p>(a) Үнэмлэх, зэрэглэл авахаар шалгалт өгөх <u>өргөдөл гаргагч нь</u>: 1/ Иргэний үнэмлэх, эсхүл холбогдох биеийн байцаалттай байна; 2/ Бичгийн шалгалтад <u>80%</u> ба түүнээс дээш үнэлгээ авсан байна; <u>/Бичгийн шалгалт нь 2 сарын хугацаанд хүчинтэй байна./</u> 3/ ИНД-65.21-ийн дагуу ур чадвараа шалгуулсан байна. 4/ Бичгийн шалгалтаа 3 сарын туршид 3 удаа хангалтгүй дүн үзүүлсэн бол сүүлчийн шалгалт авсан өдрөөс хойш тухайн шалгалтыг 3 сарын турш өгөх эрхгүй.</p> <p>(b) Шалгалт авч байгаа <u>ИНЕГ-ын шалгах эрх бүхий этгээд</u> нь энэ зүйлийн (a) хэсэгт заасан үнэлгээг авсан өргөдөл гаргагчийн бичгийн шалгалтын үнэлгээг бататгах зорилгоор аман шалгалт авсны дараа шалгалтад тэнцсэн эсэх талаар дүгнэлт гаргана.</p>	<p>70% болгон зөөлрүүлсэн</p>
<p>65.19 Шалгалтын үед хориглох зүйл</p> <p>(a) Энэ Дүрмийн дагуу шалгалтын үед аливаа этгээд нь шалгалт авч байгаа ажилтан зөвшөөрснөөс бусад тохиолдолд дараах үйлдлийг хийхгүй:</p> <ol style="list-style-type: none"> (1) бусад этгээдээс хуулах; эсхүл (2) мэдээллийн эх үүсвэр ашиглах; эсхүл (3) шалгалт авч байгаа ажилтнаас бусад этгээдтэй аливаа арга замаар харьцах; эсхүл (4) бусдын өмнөөс шалгалт өгөх; эсхүл (5) шалгалтын материалыг авч гарах; эсхүл (6) шалгалтын бичлэгийг цахим хэлбэрээр хийх. <p>(b) Энэ зүйлийн (a)-д заасан аль нэг үйлдлийг хийсэн этгээдэд дараах арга хэмжээг бүгдийг <u>эсхүл хэсэгчлэн</u> авна:</p> <ol style="list-style-type: none"> (1) тухайн сэдвийн шалгалтад тэнцээгүйд тооцох; (2) <u>өмнө нь тэнцсэн шалгалтын сэдвийг бүгдийг эсхүл хэсэгчлэн хүчингүйд тооцох</u>; (3) цаашид ИНД-ийн дагуу өгөх шалгалтад 12 сар хүртэл хугацаанд оруулахгүй байх; (4) тухайн этгээдэд энэ Дүрмийн дагуу олгосон үнэмлэх, гэрчилгээ, эсхүл зэрэглэлийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох. 	<p>65.19. Шалгалтын үед хориглох зүйлс, авах арга хэмжээ</p> <p>(a) Шалгалтын үед дараах зүйлийг хориглоно. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1/ мэдээллийн ямар нэгэн эх үүсвэр ашиглах болон бусдаас хуулах; эсхүл 2/ шалгалтын үед бусдын дэмжлэг авах; эсхүл 3/ бусдын өмнөөс шалгалт өгөх; эсхүл 4/ шалгалтын материалыг гадагш авч гарах; эсхүл 5/ ямар нэгэн хэрэгсэл ашиглан шалгалтын талаар болон шалгалтын материалаас бичлэг хийх. <p>(b) Энэ зүйлийн (a) хэсэгт заасныг зөрчсөн этгээдийн талаар ИНЕГ-ын дарга дараах шийдвэрийн <u>аль нэгийг</u> гаргана:</p> <ol style="list-style-type: none"> 1/ тухайн шалгалтанд тэнцээгүйд тооцох; эсхүл 2/ Иргэний нисэхийн дүрмийн хүрээний аливаа шалгалтанд орох эрхийг нь 12 сар хүртэл хугацаагаар хасах; эсхүл 3/ энэ дүрмээр олгогдсон аливаа үнэмлэх, зэрэглэлийн 	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

	үйлчлэлийг түр түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох.	
<p><u>65.21 НХҮ-ний ажилтны бүртгэлийн дэвтэр-Ерөнхий шаардлага</u> НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшигч нь:</p> <p>(1) НХҮ-ний сургалт болон туршлагаа Даргын хүлээн зөвшөөрөхүйц НХҮ-ний ажилтны бүртгэлийн дэвтэрт байнгын хувиршгүй хэлбэрээр бичнэ;</p> <p>(2) үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмших хүсэлтэд холбогдох бүртгэлийг баримтаар хүргүүлэхдээ, хамгийн сүүлд оруулсан мэдээллийн төгсгөлд дээр оруулсан мэдээллүүд нь үнэн зөв болохыг баталгаажуулж гарын үсэг зурсан байна.</p>	<p>2001 онд орхигдуулсан</p>	<p>2001 онд орхигдуулсан</p>
<p><u>65.23 НХҮ-ний ажилтны бүртгэлийн дэвтэрт-цаг тооцох</u></p> <p>(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, хүчинтэй НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшигч нь, НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшигчийн, НХҮ-ний багшийн, эсхүл НХҮ-ний шалгагчийн үүрэг гүйцэтгэсэн цагийг НХҮ-ний нийт цагт оруулж тооцох эрхтэй.</p> <p>(b) Энэ Дүрмийн дагуу олгосон үнэмлэх, эсхүл зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд нь энэ Дүрмийн холбогдох шаардлагыг хангаагүй байх үедээ тухайн цагийг энэ Дүрмийн дагуу аливаа зорилгод оруулж тооцохгүй.</p>	<p>2001 онд орхигдуулсан</p>	<p>2001 онд орхигдуулсан</p>
<p>65.27-д тусгагдсан</p>	<p>65.21. Мэргэжлийн ур чадварт тавигдах шаардлага</p> <p>(a) Энэ дүрмийн дагуу мэргэжлийн үнэмлэх эзэмшигч нь ИНЕГ-ын даргын тогтоосон хугацаанд тухайн зэрэглэлд хамаарах ур чадвараа шалгуулна.</p> <p>(б) Энэ зүйлийн (a) хэсэгт заасан шаардлагыг хангаагүй ажилтан үнэмлэх болон зэрэглэлд заасан эрхийг эдлэхгүй.</p>	<p>65.27-д тусгагдсан</p>
	<p>65.23. Үнэмлэхийг нөхөн олгох</p> <p>(a) НХҮ-ний ажилтны үнэмлэхийг үрэгдүүлсэн, гэмтээсэн, бичилт нь гаргацгүй болсон тохиолдолд үнэмлэхийг нөхөн олгоно.</p> <p>(б) Үнэмлэх эзэмшигч нь үнэмлэхийг нөхөн олгох тухай хүсэлтийг ИНЕГ-065/01 маягыг бөглөж, төлбөрийн баримт, үнэмлэхийг үрэгдүүлсэн тухай хуулийн байгууллагад мэдэгдсэн, болон зарлуулсан баримтын хамт ИНЕГ-ын даргад ирүүлнэ.</p>	<p>Зохиомол</p>

<p>65.25 Эрүүл мэндийн шаардлага (a) Энэ Дүрмийн дагуу олгосон сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх, эсхүл нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх эзэмшигч нь дараахаас бусад тохиолдолд тухайн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхгүй: (1) ИНД-67-гийн дагуу олгосон 3-р ангиллын хүчинтэй ЭМГ эзэмшдэг байх; (2) тухайн ЭМГ-ний бүх эрүүл мэндийн баталгаажуулсан тэмдэглэлийг дагаж мөрддөг байх.</p>	<p>65.25. Эрүүл мэндийн шаардлага (a) Нислэгийн удирдагч нь ИНД-67 “Иргэний нисэхийн эрүүл мэндийн гэрчилгээ”-д заасны дагуу 3 дугаар ангиллын эрүүл мэндийн хүчин төгөлдөр гэрчилгээтэй байна. (б) Үнэмлэх эзэмшигч нь өөрийн эрүүл мэндийн байдал муудсан тохиолдолд үнэмлэхээр олгогдох эрхээ эдлэхээс татгалзах ёстой.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>65.26. Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үүрэг гүйцэтгэх цагийн хязгаарлалт (шилжилт) Дарга, дараах нөхцөлийг харгалзан нислэгийн хөдөлгөөний удирдагчийн албан үүргээ гүйцэтгэхэд зарцуулж болох хугацаанд үүрэг гүйцэтгэх цагийн хязгаарлалтыг тогтоож болно: (1) ажлын байрны төрөл; (2) өдрийн аль цагт тухайн ажил үүргийг гүйцэтгэх; (3) тухайн байрлал, нислэгийн хөдөлгөөний нягтаршил, эсхүл нислэгийн хөдөлгөөний удирдагчид шаардлагатай оюуны төвлөрөлтийн түвшинд нөлөөлөх бусад хүчин зүйл.</p>		<p>- Part 19-өөс шилжүүлсэн</p>
<p>65.27 Ур чадварын шалгалт (a) Энэ Дүрмийн дагуу олгосон үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшигч нь Даргын тогтоосон хугацаанд, эзэмшиж байгаа үнэмлэх, эсхүл зэрэглэлийн хүрээнд Даргын шаардлагатай гэж үзсэн ур чадварын хадгалалтын шалгалт, эсхүл тестийг өгсөн байна. (b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу шалгалт, эсхүл тест өгсөн этгээд нь үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшихэд тавих шаардлагыг хангаагүй бол тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхгүй.</p>	<p>65.21-д тусгагдсан</p>	<p>65.21-д тусгагдсан</p>
	<p>65.27. Нисэхийн англи хэлний ур чадварт тавигдах шаардлага (a) Энэ дүрмийн дагуу үнэмлэх эзэмшигч нь дараах шаардлагыг хангана: 1/ Олон улсын нислэгийн үйл ажиллагаанд оролцож буй НУ-ын үнэмлэх, зэрэглэл эзэмшигч нь энэ дүрмийн хавсралт А хэсэгт</p>	

	<p>заагдсан англи хэлний ур чадварын талаарх ICAO-гийн ангиллын 4 дүгээр түвшингийн шаардлага; 2/ Олон улсын нислэгийн үйл ажиллагаанд оролцож буй НМА-ны үнэмлэх, зэрэглэл эзэмшигч нь энэ дүрмийн хавсралт А хэсэгт заагдсан англи хэлний ур чадварын талаарх ICAO-гийн ангиллын 4 дүгээр түвшингийн шаардлага.</p> <p>(б) Англи хэлний түвшинг доорхи давтамжаар шалгуулж байх шаардлагатай. 4-р түвшин / 3 жил тутамд нэг удаа / 5-р түвшин / 6 жил тутамд нэг удаа / 6-р түвшин / шалгах шаардлагагүй /</p> <p>(в) ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн, тухайн төрлийн сургалт явуулах эрх олгогдсон, эсхүл ИНЕГ–аас хүлээн зөвшөөрөгдсөн Иргэний нисэхийн сургалтын байгууллагад шалгуулан 4 ба түүнээс дээш түвшинд үнэлэгдсэн өргөдөл гаргагчийг энэ дүрмийн 65.27 (а) заалтын шаардлагыг хангасанд тооцно.</p>	<p>-Англи хэлний шаардлага ЗЦ-д байгаа</p>
<p>65.29 Согтууруулах ундаа, эсхүл <u>эмийн бодистой</u> холбоотой гэмт хэрэг Согтууруулах ундаа, эсхүл эмийн бодис хэрэглэсэн эсэхийг тогтоох хуулийн дагуух тест өгөхөөс татгалзсан үйлдлийг багтаасан, согтууруулах ундаа, эсхүл эмийн бодистой холбоотой шүүхийн шийтгэл нь тухайн этгээдийг үнэмлэх эзэмшихэд тохирох зөв хүн хэвээр байгаа эсэхийг дахин тогтоох үндэслэл болно. Тухайн шийтгэл нь <u>үнэмлэх олгохоос татгалзах, эсхүл түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоход нөлөөлж</u> болно.</p>	<p>65.29. Үнэмлэх эзэмшигчийн хүлээх үүрэг</p> <p>(а) Үнэмлэх эзэмшигч нь ажлын байранд <u>мансууруулах бодис</u>, согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдолд үнэмлэх, зэрэглэлээр олгогдсон <u>эрхээ хэрэгжүүлэхээс татгалзах үүрэгтэй</u>.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Дутуу орчуулагдсан</p>
<p>В Бүлэг - Сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх</p>	<p>Б.БҮЛЭГ. СУРАГЧ НИСЛЭГИЙН УДИРДАГЧИЙН ҮНЭМЛЭХ</p>	
<p>65.51 Хамрах хүрээ Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх олгох; (2) тухайн үнэмлэхний эрх, хязгаарлалт.</p>		
<p>65.53 Нөхцөл хангах шаардлага</p>	<p>65.51. Үнэмлэх авахад тавигдах шаардлага</p>	

<p>(а) Сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(1) 18 нас хүрсэн байх;</p> <p>(2) ИНД-67-гийн дагуу олгосон 3-р ангиллын хүчинтэй ЭМГ эзэмшдэг байх;</p> <p><u>(3) нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл эзэмшдэг байх;</u></p> <p>(4) хяналттай агаарын зайд, агаарын хөлгийн нислэгийн бүхээгт <u>2-оос доошгүй цаг танилцах дадлага хийсэн туршлагатай байх;</u></p> <p>(5) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үүрэгт ажилд хамаарах дараах сэдвийг багтаасан сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх:</p> <p>(i) Нисэхийн хууль, дүрэм: Дүрэм, журам;</p> <p>(ii) НХУ-ын төхөөрөмж: НХУ-д ашигладаг төхөөрөмжийн ажиллах зарчим, ашиглалт болон хязгаарлалт;</p> <p>(iii) Агаарын хөлгийн ерөнхий мэдлэг: нислэгийн зарчим; агаарын хөлөг, хүчний төхөөрөмж, системийн ажиллагаа болон ажиллах зарчим; агаарын хөлгийн үзүүлэлт;</p> <p>(iv) Хүний хүчин зүйл: <u>төсөөлөн бодож дүрслэн зурах чадвартай</u> холбоотой хүний хүчин чадал болон түүний хязгаарлалт, тэдний ажилд төсөөлөн бодох чадварын үүрэг ач холбогдол, НХУ-ын үйл ажиллагааны стресс үүсгэх ачаалал, төхөөрөмж болон ажлын байрны зохион байгуулалт, хүмүүсийн харилцааны гол асуудал;</p> <p>(v) Цаг уур: нисэхийн цаг уур; цаг уурын баримт бичиг, мэдээллийг ашиглах, түүнийг үнэлэх; нислэгийн үйл ажиллагаа, аюулгүй байдалд нөлөөлөх цаг агаарын аюултай үзэгдлийн гарал үүсэл, шинж чанар; өндөр хэмжих;</p> <p>(vi) Навигаци: агаарын навигацийн үндсэн зарчим; навигацийн систем болон ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээний зарчим, хязгаарлалт болон нарийвчлал;</p>	<p>(а) Өргөдөл гаргагч нь дараах шаардлагуудыг хангасан байна:</p> <p>1/ 18 нас хүрсэн байх;</p> <p>2/ ИНД-67–д заасны дагуу 3 дугаар ангиллын хүчин төгөлдөр эрүүл мэндийн гэрчилгээтэй байх;</p> <p>3/ Агаарын хөлгийн удирдлагын бүхээгт 10-аас доошгүй цаг танилцах дадлага хийсэн байх;</p> <p>4/ Нислэгийн удирдагчийн мэргэжлийн боловсрол олгох сургалтанд дараах сэдвүүдийг багтаасан сургалтанд амжилттай хамрагдсан байх. Үүнд:</p> <p>4.1. иргэний нисэхийн хууль, дүрэм;</p> <p>4.2. нислэгийн хөдөлгөөний удирдлагын тоног төхөөрөмж: ажиллах зарчим, ашиглалт, хязгаарлалт;</p> <p>4.3. агаарын хөлгийн тухай ерөнхий ойлголт: нислэгийн зарчим, агаарын хөлөг, хөдөлгүүр болон систем, тоног төхөөрөмжийн ажиллагааны ерөнхий зарчим, техникийн үзүүлэлтүүд;</p> <p>4.4. хүний хүчин зүйл: нислэгийн хөдөлгөөний удирдлагын ажлын үүрэг хариуцлага, ажлын ачаалал, алжаал ядаргаа, хүний чадвар, боломж, хүмүүсийн хоорондын харилцааны асуудлууд, ажлын байрны зохион байгуулалт, тоног төхөөрөмж гэх мэт.</p> <p>4.5. цаг уурын мэдээлэл: аэронавигацийн цаг уур, цаг уурын баримт, мэдээллийг хүлээн авч зөв хэрэглэх, нислэгийн үйл ажиллагаа, аюулгүй байдалд нөлөөлөх цаг агаарын өөрчлөлтийн эх үүсвэр, онцгой шинж чанар, өндрийн хэмжигдэхүүн;</p> <p>4.6. навигаци: агаарын зай дахь навигацийн үндсэн зарчим, агаарын хөлгийн болон газрын навигацийн систем, ил харааны зарчим, тэдгээрийн хязгаарлалт болон нарийвчлал, тоног төхөөрөмж;</p> <p>4.7. ажлын горим: нислэгийн хөдөлгөөний удирдлага,</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-10-аас доошгүй цаг танилцах дадлага хийсэн байх шаардлагыг 2-оос доошгүй цаг болгосон.</p>
--	---	---

(vii) **Үйл ажиллагааны журам:** НХУ, харилцаа холбоо, радио холбоо, нислэгийн холбооны стандарт хэллэгийн журам (хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн); холбогдох нисэхийн бичиг баримтыг ашиглах; нислэгтэй холбоотой аюулгүй байдлын практик.

(b) Энэ зүйлийн (a)(5)-д амжилттай дүүргэсэн байхыг шаардсан сургалтыг дараах байгууллага зохион байгуулна:

(1) ИНД-[172](#)-ын дагуу олгосон НХУ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол; эсхүл

(2) Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагаар зөвшөөрөгдсөн нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол.

харилцаа холбоо, радио холбоо, нислэгийн холбооны хэллэг (чиглэлийн болон чиглэлийн бус нислэг, онцгой нөхцөл байдлын), нисэхийн бичиг баримтыг ашиглах, нислэгтэй холбоотой аюулгүй ажиллагааны дадлага туршлага.

(б) Энэ зүйлийн (a) хэсгийн 4/-т хамаарах сургалт, дадлагыг дараах байгууллага гүйцэтгэсэн байна:

1/ [ИНД-141-ийн](#) дагуу гэрчилгээжсэн, тухайн төрлийн сургалт дадлага явуулах эрх олгогдсон эсхүл ИНЕГ-аас хүлээн зөвшөөрөгдсөн Иргэний нисэхийн сургалтын байгууллага;

[\(в\) Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч аль нэг улсаас олгосон НУ-ийн хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэх эзэмшигчийг энэ зүйлийн \(a\) хэсгийн 4/-т шаардсан агаарын хөлгийн тухай ерөнхий мэдлэг, цаг уурын болон навигацийн талаарх шалгалтыг өгсөнд тооцож болно.](#)

[\(г\) Өргөдөл гаргагч нь зөвшөөрөгдсөн сургалт дадлагад хамрагдсан, мөн багшлах зэрэглэлтэй НУ-ийн хяналт дор нислэгийн хөдөлгөөний удирдлагын бодит ажиллагаатай 3 сараас доошгүй хугацаагаар танилцсан байх.](#)

-Зохиомол

65.55 Эрх, хязгаарлалт

Сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх нь тухайн эзэмшигчид, дараах зорилгоор НХУ-ын ажлын дадлага туршлага олж авах НХУ-ын ажил үүргийг, НХУ-ний багшийн зэрэглэл эзэмшигчийн хяналтан дор гүйцэтгэх эрхийг олгоно:

(1) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх, зэрэглэл, эсхүл зөвшөөрөл авахаар мэргэших; эсхүл

(2) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх, зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн хүчинтэй байдлыг сэргээх.

65.53. Эрх, хязгаарлалт

(a) Сурагч нислэгийн удирдагчийн үнэмлэх эзэмшигч нь нислэгийн удирдагчийн ажлыг гүйцэтгэх дадлага, туршлага олж авах зорилгоор энэ дүрмийн [И бүлэгт заагдсан](#) нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний багшлах зэрэглэлтэй нислэгийн удирдагчийн хяналтан дор нислэг хөдөлгөөн удирдлагын үйл ажиллагаанд дараах хэлбэрээр оролцох эрхтэй:

1/ Нислэгийн удирдагчийн үнэмлэх авахад бэлтгэх зорилгоор;

2/ Нислэгийн хөдөлгөөний удирдлагатай танилцах зорилгоор.

-Орчуулга, найруулга зассан

	<p>65.55. Дадлага туршлагад тавигдах шаардлага <u>(а) Үнэмлэх эзэмшигч нь энэ дүрмийн дагуу сурагч нислэгийн удирдагчийн үнэмлэх олгогдсоноос хойш 12 сарын хугацаанд НУ-ийн үнэмлэх олгогдоогүй бол ИНЕГ-ын даргад тусгайлан өргөдөл гаргана.</u></p>	Зохиомол
<p>С Бүлэг — Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх</p>	<p>В БҮЛЭГ. НИСЛЭГИЙН УДИРДАГЧИЙН ҮНЭМЛЭХ</p>	
<p>65.101 Хамрах хүрээ <u>Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:</u> <u>(1) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх олгох;</u> <u>(2) тухайн үнэмлэхний эрх, хязгаарлалт.</u></p>		-Орхигдуулсан
<p>65.103 Нөхцөл хангах шаардлага (а) Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байна: <u>(1) энэ Дүрмийн дагуу олгосон хүчинтэй сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх, эсхүл Конвенцийн хэлэлцэн тохирогч улсаас олгосон хүчинтэй нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх эзэмшдэг байх;</u> (2) 21 нас хүрсэн байх; <u>(3) дараах туршлагатай байх:</u> <u>(i) энэ Дүрмийн дагуу олгосон сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэхний эрхийг 3 сараас доошгүй хугацаанд хэрэгжүүлсэн; эсхүл</u> <u>(ii) Конвенцийн хэлэлцэн тохирогч улсаас олгосон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэхний эрхийг тухайн улсад 2-оос доошгүй жил хэрэгжүүлсэн.</u> (4) хяналттай агаарын зайд, агаарын хөлгийн нислэгийн бүхээгт 10-аас доошгүй цаг дадлага хийсэн туршлагатай байх; (5) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үүрэгт ажилтай холбоотой шалгалтыг дараах сэдвээр амжилттай өгсөн байх: (i) Нисэхийн хууль, дүрэм: Дүрэм, журам; (ii) НХУ-ын төхөөрөмж: НХУ-д ашиглагдах төхөөрөмжийн ажиллах зарчим, ашиглалт болон хязгаарлалт; (iii) Агаарын хөлгийн ерөнхий мэдлэг: нислэгийн зарчим; агаарын хөлөг, хүчний төхөөрөмж, системийн</p>	<p>65.103. Үнэмлэх авахад тавигдах шаардлага (а) Өргөдөл гаргагч нь дараах шаардлагуудыг хангасан байна:</p> <p>1/ 21 нас хүрсэн байх; 2/ ИНД-67–д заасны дагуу 3 дугаар ангиллын эрүүл мэндийн хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх; 3/ Агаарын хөлгийн удирдлагын бүхээгт 5-аас доошгүй цаг танилцах дадлага хийсэн байх; <i>Энэ зүйлийн (а)7-д тусгагдсан</i></p> <p>4/ Дараах сэдвүүдийг багтаасан сургалтад амжилттай хамрагдсан байх. Үүнд: 4.1. иргэний нисэхийн хууль, дүрэм; 4.2. нислэгийн хөдөлгөөний удирдлагын тоног төхөөрөмж: ажиллах зарчим, ашиглалт, хязгаарлалт; 4.3. агаарын хөлгийн тухай ерөнхий ойлголт: нислэгийн зарчим, агаарын хөлөг, хөдөлгүүр болон систем, тоног төхөөрөмжийн ажиллагааны ерөнхий</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p> <p>-Орхигдуулсан</p> <p>-10-аас доошгүй цагын дадлагыг 5 болгосныг буцааж 10 болгосон</p>

ажиллагааны болон ажиллах зарчим; агаарын хөлгийн үзүүлэлт;

(iv) **Хүний хүчин зүйл:** [төсөөлөн бодож дүрслэн зурах чадвартай](#) холбоотой хүний хүчин чадал болон түүний хязгаарлалт, тэдний ажилд төсөөлөн бодох чадварын үүрэг ач холбогдол, НХУ-ын үйл ажиллагааны стресс үүсгэх ачаалал, төхөөрөмж болон ажлын байрны зохион байгуулалт, хүмүүсийн харилцааны гол асуудал;

(v) **Цаг уур:** нисэхийн цаг уур; цаг уурын баримт бичиг, мэдээллийг ашиглах, түүнийг үнэлэх; нислэгийн үйл ажиллагаа, аюулгүй байдалд нөлөөлөх цаг агаарын аюултай үзэгдлийн гарал үүсэл, шинж чанар; өндөр хэмжих;

(vi) **Навигаци:** агаарын навигацийн үндсэн зарчим; навигацийн систем болон ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээний зарчим, хязгаарлалт болон нарийвчлал;

(vii) **Үйл ажиллагааны журам:** НХУ, харилцаа холбоо, радио холбоо, нислэгийн холбооны стандарт хэллэгийн журам (хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн); холбогдох нисэхийн бичиг баримтыг ашиглах; нислэгтэй холбоотой аюулгүй байдлын практик;

(6) Энэ Дүрмийн G Бүлгийн дагуу олгосон нэгээс доошгүй нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэлд тавих сургалт, туршлагын болон үнэлгээ хийх шаардлагыг хангасан байх;

(7) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн ажил үүргийг чадварлагаар гүйцэтгэх чадвараа [НХУ-ний шалгагчийн зэрэглэл эзэмшигчид](#) шалгуулсан байх.

(b) Конвенцийн хэлэлцэн тохирогч улсаас олгосон хүчинтэй нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх эзэмшигчийг энэ зүйлийн (a)(5)-д шаардсан агаарын

зарчим, техникийн үзүүлэлтүүд;

4.4. **хүний хүчин зүйл:** нислэгийн хөдөлгөөний удирдлагын ажлын үүрэг хариуцлага, ажлын ачаалал, алжаал ядаргаа, хүний чадвар, боломж, хүмүүсийн хоорондын харилцааны асуудлууд, ажлын байрны зохион байгуулалт, тоног төхөөрөмж гэх мэт.

4.5. **цаг уурын мэдээлэл:** аэронавигацийн цаг уур, цаг уурын баримт, мэдээллийг хүлээн авч зөв хэрэглэх, нислэгийн үйл ажиллагаа, аюулгүй байдалд нөлөөлөх цаг агаарын өөрчлөлтийн эх үүсвэр, онцгой шинж чанар, өндрийн хэмжигдэхүүн;

4.6. **навигаци:** агаарын зай дахь навигацийн үндсэн зарчим, агаарын хөлгийн болон газрын навигацийн систем, ил харааны зарчим, тэдгээрийн хязгаарлалт болон нарийвчлал, тоног төхөөрөмж;

4.7. **ажлын горим:** нислэгийн хөдөлгөөний удирдлага, харилцаа холбоо, радио холбоо, нислэгийн холбооны хэллэг (чиглэлийн болон чиглэлийн бус нислэг, онцгой нөхцөл байдлын), нисэхийн бичиг баримтыг ашиглах, нислэгтэй холбоотой аюулгүй ажиллагааны дадлага туршлага.

5/ Энэ дүрмийн Ж Бүлгийн 65.305-ын холбогдох шаардлагыг;

6/ [ИНЕГ-ын шалгах эрх бүхий этгээдэд](#) холбогдох шалгалтыг өгч шалгуулсан байх;

7/ Чикагогийн конвенцийн Хэлэлцэн тохирогч аль нэг улсаас олгосон хүчин төгөлдөр үнэмлэхний дагуу 2-оос доошгүй жил ажил үүрэг гүйцэтгэсэн дадлага туршлагатай байх;

(в) Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч аль нэг улсаас олгосон нислэгийн удирдагчийн хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэх эзэмшигчийг энэ зүйлийн (a) хэсгийн 4/-т шаардсан агаарын хөлгийн тухай ерөнхий мэдлэг, цаг уурын болон навигацийн талаарх шалгалтыг өгсөнд тооцож болно.

(б) Энэ зүйлийн (a) хэсгийн 4/-т хамаарах сургалт, дадлагыг дараах байгууллагад гүйцэтгэсэн байна:

<p>хөлгийн тухай ерөнхий мэдлэг, цаг уурын болон навигацийн шалгалтыг өгсөнд тооцно.</p> <p>(с) Энэ зүйлийн (а)(5)-д шаардсан шалгалтыг дараах байгууллага авна:</p> <p>(1) ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн шалгалтыг авахыг зөвшөөрдөг бол; эсхүл</p> <p>(2) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн шалгалтыг авахыг зөвшөөрдөг бол.</p>	<p>1/ ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн, тухайн төрлийн сургалт дадлага явуулах эрх олгогдсон, эсхүл ИНЕГ-аас хүлээн зөвшөөрөгдсөн Иргэний нисэхийн сургалтын байгууллага;</p> <p>2/ ИНД-172-ын дагуу гэрчилгээжсэн, тухайн төрлийн сургалт дадлага явуулах эрх олгогдсон байгууллага.</p>	
<p>65.105 Эрх Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх нь тухайн эзэмшигчид дараах эрхийг хэрэгжүүлэх эрх олгоно:</p> <p>(1) сурагч-нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэхний;</p> <p>(2) НМА-ны үнэмлэхний;</p> <p>(3) эзэмшиж байгаа хүчинтэй нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэлийн болон зөвшөөрлийн.</p>	<p>65.105. Эрх, хязгаарлалт (а) НУ-ийн үнэмлэх эзэмшигч нь дараах үнэмлэх, зэрэглэлээр олгогдох эрхийг хэрэгжүүлж болно: 1/ Нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх, зэрэглэл; 2/ тухайн үнэмлэх эзэмшигчид олгогдсон аливаа хүчин төгөлдөр зэрэглэлүүд.</p> <p>(б) ИНЕГ-ын даргаас зохих зөвшөөрөл олгогдоогүй үнэмлэх эзэмшигч үйлдвэрлэлийн орчинд ажилтнуудад зааварчлага өгөхийг хориглоно.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p>65.107 Туршлага хадгалах шаардлага Үнэмлэх эзэмшигч нь энэ Дүрмийн дагуу олгосон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэхний эрхийг өмнө үргэлжилсэн 5 жилийн дотор хэрэгжүүлээгүй бол, тухайн үнэмлэхний эрхийг дахин хэрэгжүүлэхийн өмнө 65.103(а)(7)-гийн шаардлагыг хангасан байна.</p>	<p>2001 онд орхигдуулсан</p>	<p>-Орхигдуулсан</p>
<p>D Бүлэг-Сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх</p>	<p>Г БҮЛЭГ. НӨӨЦ</p>	
<p>65.151 Хамрах хүрээ Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:</p> <p>(1) сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх олгох;</p> <p>(2) тухайн үнэмлэхний эрх, хязгаарлалт.</p>		
<p>65.153 Нөхцөл хангах шаардлага (а) Сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(1) 18 нас хүрсэн байх;</p> <p>(2) нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл эзэмшдэг байх;</p>	<p>2001 онд орхигдуулсан</p>	<p>-Орхигдуулсан</p>

(3) агаарын хөлгийн нислэгийн бүхээгт 2-оос доошгүй цаг танилцах дадлага хийсэн туршлагатай байх;

(4) НМА-ны үүрэгт ажилд хамаарах дараах сэдвийг багтаасан сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх:

- (i) НХУ-ний ерөнхий мэдлэг: Монгол Улсын агаарын зайд үзүүлж байгаа НХУ;
- (ii) Үйл ажиллагааны журам: радио холбооны журам, стандарт хэллэг, радио холбооны сүлжээ;
- (iii) Нисэхийн хууль, дүрэм: Дүрэм, журам;
- (iv) Хүний хүчин зүйл: төсөөлөн бодож дүрслэн зурах чадвартай холбоотой хүний хүчин чадал болон түүний хязгаарлалт, тэдний ажилд төсөөлөн бодох чадварын үүрэг ач холбогдол, НХУ-ын үйл ажиллагааны стресс үүсгэх ачаалал, төхөөрөмж болон ажлын байрны зохион байгуулалт, хүмүүсийн харилцааны гол асуудал;
- (v) Радио холбооны төхөөрөмж: нисэхийн байгууламж дахь радио холбооны төхөөрөмжийн ажиллах зарчим, ашиглалт болон хязгаарлалт.

(b) Энэ зүйлийн (a)(4)-т амжилттай дүүргэсэн байхыг шаардсан сургалтыг дараах байгууллага зохион байгуулна:

- (1) ИНД-172-ын дагуу олгосон НХУ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол; эсхүл
- (2) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол.

65.155 Эрх, хязгаарлалт

Сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх нь эзэмшигчид, дараах зорилгоор НМА-ны ажлын дадлага туршлага олж авахаар НМА-ны ажил үүргийг хүчинтэй НХУ-ний багшийн зэрэглэл эзэмшигчийн хяналтан дор гүйцэтгэх эрхийг олгоно:

- (1) НМА-ны үнэмлэх, зэрэглэл, эсхүл зөвшөөрөл авахаар мэргэших; эсхүл
- (2) НМА-ны үнэмлэх, зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн хүчинтэй байдлыг сэргээх.

2001 онд орхигдуулсан

2001 онд орхигдуулсан

-Орхигдуулсан

-Орхигдуулсан

Е Бүлэг— Нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх	Д БҮЛЭГ. НИСЛЭГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТНЫ ҮНЭМЛЭХ	
<p>65.201 Хамрах хүрээ Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) НМА-ны үнэмлэх олгох; (2) тухайн үнэмлэхний эрх, хязгаарлалт.</p>		-Орхигдуулсан
<p>65.203 Нөхцөл хангах шаардлага (а)НМА-ны үнэмлэх эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(1) <u>энэ Дүрмийн дагуу олгосон хүчинтэй сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх эзэмшдэг байх;</u> (2) сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэхний эрхийг 2 сараас доошгүй хугацаанд хэрэгжүүлсэн туршлагатай байх; (3) агаарын хөлгийн нислэгийн бүхээгт <u>10-аас доошгүй цаг дадлага хийсэн туршлагатай байх;</u> (4) НМА-ны үүрэгт ажилд хамаарах дараах сэдвээр шалгалтыг амжилттай өгсөн байх: (i) НХҮ-ний ерөнхий мэдлэг: Монгол Улсын агаарын зайд үзүүлж байгаа НХҮ; (ii) Үйл ажиллагааны журам: радио холбооны журам, стандарт хэллэг, радио холбооны сүлжээ; (iii)Нисэхийн хууль: Дүрэм,журам; (iv)Хүний хүчин зүйл: <u>төсөөлөн бодож дүрслэн зурах чадвартай холбоотой хүний хүчин чадал болон түүний хязгаарлалт, тэдний ажилд төсөөлөн бодох чадварын үүрэг ач холбогдол, НХУ-ын үйл ажиллагааны стресс үүсгэх ачаалал, төхөөрөмж болон ажлын байрны зохион байгуулалт, хүмүүсийн харилцааны гол асуудал;</u> (v) Радио холбооны төхөөрөмж: нисэхийн байгууламж дахь радио холбооны төхөөрөмжийн ажиллах зарчим, ашиглалт болон хязгаарлалт; (5) <u>Н Бүлгийн дагуу олгосон НМА-ны нэгээс доошгүй зэрэглэлд тавих сургалтын болон үнэлгээ хийх</u></p>	<p>65.203. Үнэмлэх авахад тавигдах шаардлага (а) Өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p><u>1/ 18 нас хүрсэн;</u> <u>2/ Өмнөх 12 сарын хугацаанд НХҮ-ний зохих сургалтанд хамрагдсан;</u> <u>3/ Агаарын хөлгийн удирдлагын бүхээгт 5-аас доошгүй цаг танилцах дадлага хийсэн байх;</u></p> <p>4/ НМА-ны үүрэгт хамаарах дараах сэдвүүдээр шалгалт өгч хангалттай үнэлгээ авсан байна. Үүнд: 4.1. иргэний нисэхийн хууль, дүрэм; 4.2. НХҮ-ний ерөнхий мэдлэг; 4.3. үйл ажиллагааны горим: нислэгийн холбооны хэллэг, теле холбооны сүлжээний ажиллагаа; 4.4. хүний хүчин зүйл: <u>нислэгийн хөдөлгөөний удирдлагын ажлын үүрэг хариуцлага, ажлын ачаалал, хүний чадвар, боломж, хүмүүсийн хоорондын харилцааны асуудлууд гэх мэт;</u> 4.5. теле холбооны тоног төхөөрөмж: ажиллах зарчим, аэронавигацийн мэдээллийн хэлбэр, ашиглах зарчим.</p> <p>5/ Дараах чиглэлээр, Нислэгийн мэдээллийн ажилтны</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Зохиомолоор өөрчилсөн</p>

шаардлагыг хангасан байх:

(б) НХҮ-ний шалгагчийн зэрэглэл эзэмшигчид, дараах ажиллагааг багтаасан НМА-ны үүргийг чадварлагаар гүйцэтгэх чадвараа шалгуулсан байх:

- (i) зэрэглэл авахаар зорьж байгаа ажлын байранд ашиглаж байгаа **радио** холбооны төхөөрөмжийг ажиллуулах;
- (ii) радио-холбооны мэдээллийг үр дүнтэй, алдаагүй нягт нямбай дамжуулах, хүлээн авах.

(б) Энэ зүйлийн (а)(4)-т шаардсан шалгалтыг дараах байгууллага авна:

- (1) ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн шалгалтыг авахыг зөвшөөрдөг бол; эсхүл
- (2) ИНД-141-ийн олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн шалгалтыг авахыг зөвшөөрдөг бол.

үүргийг гүйцэтгэх чадвараа шалгуулсан байх:

- 5.1. ашиглаж байгаа холбооны тоног төхөөрөмжийн ашиглалт;
- 5.2. аэронавигацийн мэдээллийг түргэн шуурхай, алдаагүй дамжуулах, хүлээн авах.

(б) Энэ зүйлийн (а) хэсгийн 4/-т хамаарах сургалт, дадлагыг дараах байгууллагад гүйцэтгэсэн байна:

- 1/ ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн, тухайн төрлийн сургалт дадлага явуулах эрх олгогдсон, эсхүл ИНЕГ-аас хүлээн зөвшөөрөгдсөн Иргэний нисэхийн сургалтын байгууллага;
- 2/ ИНД-172-ын дагуу гэрчилгээжсэн, тухайн төрлийн сургалт дадлага явуулах эрх олгогдсон байгууллага;
- 3/ ИНЕГ-ын шалгах эрх бүхий этгээдэд холбогдох шалгалтыг өгч шалгуулсан байх.

65.205 Эрх, хязгаарлалт

(а) Энэ зүйлийн (b)-г харгалзан, НМА-ны үнэмлэх нь тухайн эзэмшигчид дараах эрхийг хэрэгжүүлэх эрх олгоно:

- (1) сурагч-нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэхний;
- (2) эзэмшиж байгаа хүчинтэй НМА-ны зэрэглэл болон зөвшөөрлийн.

(b) Үнэмлэх эзэмшигч нь тухайн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхийн өмнө эзэмшиж байгаа зөвшөөрөгдсөн зэрэглэлд хамаарах нисэхийн байгууламжид ашиглагдаж байгаа төхөөрөмжийн төрөл болон үйл ажиллагааны журмын талаарх хүчинтэй мэдээлэлтэй танилцсан байна.

65.205. Эрх, хязгаарлалт

(а) НМА-ны үнэмлэх эзэмшигч нь аэронавигацийн үйлчилгээний нэгжид нислэгийн мэдээллийн ажилтнаар ажиллах эрхийг эдэлнэ.

(б) НМА-ны үнэмлэх эзэмшигч нь дадлагыг НХҮ-ний багшлах зэрэглэлтэй ажилтны шууд удирдлага дор гүйцэтгэнэ.

(в) Тухайн үнэмлэхээр олгосон эрхийг эдлэхээс өмнө үнэмлэх эзэмшигч нь аэронавигацийн үйлчилгээний нэгжид мөрдөж байгаа үйл ажиллагааны журам болон ашиглагдаж буй тоног төхөөрөмжид хамаарах бүх мэдээлэлтэй танилцсан байна.

-Орчуулга,
найруулга зассан

F Бүлэг - Нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл

E БҮЛЭГ. НӨӨЦ

<p>65.251 Хамрах хүрээ Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) НХҮ-ний ажилтанд нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл олгох; (2) тухайн зэрэглэлийн эрх, хязгаарлалт</p>	<p style="text-align: center;">2001 онд орхигдуулсан</p>	<p style="text-align: center;">-Орхигдуулсан</p>
<p>65.253 Нөхцөл хангах шаардлага (а) Энэ Дүрмийн дагуу нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байна: (1) дараах байгууллагын зохион байгуулсан, бичгийн шалгалтыг багтаасан нисэхийн радио-холбооны дадлага болон журмын сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх: (i) ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулж, шалгалт авахыг зөвшөөрдөг бол; эсхүл (ii) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулж, шалгалт авахыг зөвшөөрдөг бол; (2) НХҮ-ний багшийн зэрэглэл, эсхүл багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчид дараах чадвараа шалгуулсан байх: (i) нисэхийн радио-холбооны төхөөрөмжийн удирдлагыг зөв ажиллуулах болон тохируулах; (ii) хүчинтэй мөрдөгдөж байгаа журмын дагуу яриан мэдээг чадварлагаар хүлээн авч, дамжуулах.</p>		
<p>65.255 Зэрэглэл олгох (а) НХҮ-ний багшийн зэрэглэл, эсхүл багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч нь, 65.253-т заасан нислэгийн радио-холбооны операторын зэрэглэлд тавих шаардлага хангагдсан гэж үзвэл, тухайн этгээдийн бүртгэлийн дэвтэрт өөрийн нэр, үнэмлэх, зэрэглэлийн дугаар, гарын үсэг; нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл олгосон огноо болон дараах мэдэгдлийг оруулж, зэрэглэл олгоно: [тухайн этгээдийн нэр] нь ИНД-65-д заасан нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл олгоход тавих шаардлагыг хангасан болохыг тодорхойлов.</p>	<p style="text-align: center;">2001 онд орхигдуулсан</p>	

<p>(b)НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшигч нь Даргад хүсэлт гаргаж, зохих төлбөрийн баримтыг хүргүүлж, радио-холбооны операторын зэрэглэлийг үнэмлэхэндээ нэмж тэмдэглүүлж болно.</p>		
<p>65.257 Эрх, хязгаарлалт Нислэгийн радио-холбооны операторын зэрэглэл нь тухайн этгээдэд нисэхийн хөдөлгөөнт холбооны үйлчилгээнд зориулсан давтамж дээр ажилладаг агаарын хөлөг, нисэхийн радио станц, эсхүл газрын хөдөлгөөнт станцыг ажиллуулах эрх олгоно, хэрэв дамжуулагч нь: (1) зөвхөн энгийн гадна удирдлага ашиглахыг шаарддаг бол; (2) цацагдаж байгаа давтамжийн тогтвортой байдлыг автоматаар хадгалдаг бол.</p>		
<p>Г Бүлэг — Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл</p>	<p>Ж БҮЛЭГ. НИСЛЭГИЙН УДИРДАГЧИЙН ЗЭРЭГЛЭЛ</p>	
<p>65.301 Хамрах хүрээ Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) дараах нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл болон түүний зөвшөөрөл олгох: (i) аэродромын удирдлагын зэрэглэл; (ii) ойртолтын процедур-удирдлагын зэрэглэл; (iii) ойртолтын ажиглалтын-удирдлагын зэрэглэл; (iv) бүсийн процедур-удирдлагын зэрэглэл; (v) бүсийн ажиглалтын-удирдлагын зэрэглэл; (2) тухайн зэрэглэлийн эрх, хязгаарлалтыг тогтоох; (3) тухайн этгээдийн нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл нь дараах зэрэглэлд хамаарч байгаа бол: (i) ойртолтын удирдлагын зэрэглэлийг ойртолтын процедур-удирдлагын зэрэглэлд; (ii) ойртолтын радарын удирдлагын зэрэглэлийг ойртолтын ажиглалтын-удирдлагын зэрэглэлд; (iii) бүсийн удирдлагын зэрэглэлийг бүсийн процедур-удирдлагын зэрэглэлд; (iv) бүсийн радарын удирдлагын зэрэглэлийг бүсийн ажиглалтын-удирдлагын зэрэглэлд тооцох.</p>	<p>2001 онд орхигдуулсан</p>	<p>-Орхигдуулсан</p>
<p>65.303 Нөхцөл хангах шаардлага (a) Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл болон</p>	<p>65.303. Зэрэглэл авахад тавигдах шаардлага (a) Өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:</p>	

тухайн [зэрэглэлд эхний зөвшөөрөл](#) авах [этгээд нь](#) дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

(1) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх эзэмшдэг байх;

(2) тухайн зэрэглэл болон зөвшөөрөлтэй холбоотой дараах сэдвээр сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх:

(i) аэродромын удирдлагын зэрэглэл: аэродромын байрлалын зураг; бодит үзүүлэлт болон ил харааны туслах хэрэгсэл, тэмдэглэгээ, агаарын зайн бүтэц зохион байгуулалт; холбогдох хууль, дүрэм, ажлын горим, мэдээллийн эх сурвалж; агаарын навигацийн байгууламж; НХУ-ын төхөөрөмж болон түүний ашиглалт; газрын бартаа болон газар зүйн онцлог газар; нислэгийн хөдөлгөөний шинж чанар/үзүүлэлт; цаг агаарын аюултай үзэгдэл; онцгой нөхцөл болон эрэн хайх, авран туслах төлөвлөгөө;

(ii) ойртолтын болон бүсийн процедур-удирдлагын зэрэглэл: агаарын зайн бүтэц зохион байгуулалт; холбогдох хууль, дүрэм, ажлын горим, мэдээллийн эх сурвалж; агаарын навигацийн байгууламж; НХУ-ын төхөөрөмж болон түүний ашиглалт; газрын бартаа болон газар зүйн онцлог газар; нислэгийн хөдөлгөөний шинж чанар/үзүүлэлт болон хөдөлгөөний урсгал; цаг агаарын аюултай үзэгдэл; онцгой нөхцөл болон эрэн хайх, авран туслах төлөвлөгөө;

(iii) ойртолтын ажиглалтын болон бүсийн ажиглалтын-удирдлагын зэрэглэл: тухайн хариуцлагын бүсэд хэрхэн нөлөөлөх хэмжээгээр нь энэ хэсгийн (2)(ii) дээр нэмж радар, бусад ажиглалтын систем болон холбогдох төхөөрөмжийн зарчим, хэрэглээ болон хязгаарлалт; хангалттай газрын бартааг давах зайтай болохыг бататгах журмыг багтаасан, ойртолтын, эсхүл бүсийн радарын удирдлагын үйлчилгээнд ашиглах, холбогдох журам;

[\(3\) НХУ-ний Багшийн зохих зэрэглэл эзэмшигчийн шүүд хяналтан дор, дараах түршлагыг эзэмшсэн байх:](#)

1/ Энэ дүрмийн дагуу нислэгийн удирдагчийн тухайн зэрэглэлийн дагуу үүрэгт ажлыг гүйцэтгэх шаардлагын хүрээнд [65.305 \(a\)-д](#) заасан сэдвүүдийг багтаасан сургалтад амжилттай хамрагдсан байх;

2/ Энэ дүрмийн [65.305-ын \(б\)-д](#) заасан зэрэглэлүүдийн аль нэгийг нь хувьд дадлага, туршлагад тавигдах шаардлагыг хангасан байх;

3/ [ИНЕГ-ын шалгах эрх бүхий этгээдэд](#) НУ-ийн ажил үүргийг гүйцэтгэх үр чадвараа шалгуулсан байх.

305(a)-д байгаа

305(б)-д байгаа

-Орхигдуулсан

(i) аэродромын удирдлагын зэрэглэл: тухайн зэрэглэл авахаар зорьж байгаа аэродромд 90-ээс доошгүй цаг, эсхүл 1 сарын аль их хугацаанд аэродромын удирдлагын үйлчилгээ гүйцэтгэсэн;

(ii) ойртолтын процедур-удирдлагын, ойртолтын ажиглалтын- удирдлагын, бүсийн процедур-удирдлагын, бүсийн ажиглалтын-удирдлагын зэрэглэл: зэрэглэл авахаар зорьж байгаа удирдлагын үйлчилгээг 180-аас доошгүй цаг, эсхүл 3 сарын аль их хугацаанд, тухайн зэрэглэл авахаар зорьж байгаа нэгж дээр гүйцэтгэсэн;

(4) энэ хэсгийн (2)-т заасан сэдвээр, дараах байгууллагын зохион байгуулсан тухайн зэрэглэлийн эрхтэй холбоотой шалгалтыг амжилттай өгсөн байх:

(i) ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн шалгалт авахыг зөвшөөрдөг бол; эсхүл

(ii) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн шалгалт авахыг зөвшөөрдөг бол;

(5) зэрэглэл авахаар зорьж байгаа нэгж дээр, удирдлагын үйлчилгээг аюулгүй, эрэмбэ дараатай, шүүрхай үзүүлэхэд шаардлагатай үр чадвар, нөхцөл байдлыг зөв тодорхойлох болон гүйцэтгэх чадвараа НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшигчид шалгуулсан байх.

(b) Энэ зүйлийн (a)(2)-т амжилттай дүүргэсэн байхыг шаардсан сургалтыг дараах байгууллага зохион байгуулах ёстой:

(1) энэ зүйлийн (a)(4)(i)-д заасан НХҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулах эрх олгодог бол; эсхүл

(2) энэ зүйлийн (a)(4)(ii)-т заасан Нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулах эрх олгодог бол.

(c) Эзэмшиж байгаа нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэлдээ нэмэлт байрлалд зөвшөөрөл авах этгээд нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

(б) Энэ зүйлийн (a) хэсэгт хамаарах **сургалт, дадлагыг** дараах байгууллагад гүйцэтгэсэн байна:

1/ ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн, тухайн төрлийн сургалт дадлага явуулах эрх олгогдсон, эсхүл ИНЕГ-аас хүлээн зөвшөөрөгдсөн Иргэний нисэхийн сургалтын байгууллага;

2/ ИНД-172-ын дагуу гэрчилгээжсэн, тухайн төрлийн сургалт дадлага явуулах эрх олгогдсон байгууллага.

-Орхигдуулсан

- [\(1\) энэ зүйлийн \(а\)\(2\)-т шаардсан нэмэлт байрлалын сургалтыг амжилттай дүүргэсэн байх;](#)
[\(2\) энэ зүйлийн \(а\)\(5\)-д шаардсан нэмэлт байрлалд ажиллахад тавих шаардлагыг хангасан байх.](#)

65.305 Зэрэглэл олгох

(a) НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшигч нь нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэлд тавих [65.303\(а\)-ийн](#) шаардлага хангагдсан гэж үзвэл нислэгийн хөдөлгөөний удирдагчийн бүртгэлийн дэвтэрт, олгосон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэлийг бичиж, тухайн зэрэглэлийг ашиглах нөхцөл, зөвшөөрсөн байрлалын нэр; өөрийн нэр, үнэмлэх зэрэглэлийн дугаар, гарын үсэг, тухайн нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл олгосон огноо болон дараах мэдэгдлийг оруулна:
 [нислэгийн хөдөлгөөний удирдагчийн нэр] нь дор заасан [ИНД-65-ын](#) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл олгох шаардлагыг хангасан болохыг тодорхойлов.

(b) НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшигч нь нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэлийн нэмэлт зөвшөөрөлд тавих [65.303\(с\)-гийн шаардлага хангагдсан гэж](#) үзвэл нислэгийн хөдөлгөөний удирдагчийн бүртгэлийн дэвтэрт, олгосон зэрэглэлийг зөвшөөрсөн байрлалын нэр, өөрийн нэр, үнэмлэх зэрэглэлийн дугаар, гарын үсэг

65.305. Зэрэглэл

(a) Холбогдох сургалтад хамрагдаж хангалттай үнэлгээ авсан, зохих зэрэглэлд хамаарах дараах шаардлагыг хангасан НҮ-ийн үнэмлэх эзэмшигчид харгалзах [зэрэглэлүүдийг тогтооно](#). Үүнд:
 1/ аэродромын нислэгийн удирдлагын зэрэглэл: аэродромын байрлал, зохион байгуулалт, ил харааны тоноглол, агаарын зайн бүтэц, холбогдох хууль, дүрэм, ажлын горим, мэдээллийн эх үүсвэр, нислэгийн удирдлагын тоног төхөөрөмж, тэдгээрийн ашиглалт, орон нутгийн онцлог, нислэгийн хөдөлгөөний онцлог, цаг агаарын үзэгдэл, онцгой тохиолдол, нөхцөл, эрэн хайх, авран туслах төлөвлөгөө;
 2/ ойртолтын болон бүсийн удирдлагын зэрэглэл: агаарын зайн бүтэц зохион байгуулалт, холбогдох хууль, дүрэм, аэронавигацийн тоног төхөөрөмж, тэдгээрийн хүчин чадал, орон нутгийн онцлог, нислэгийн хөдөлгөөний онцлог, цаг агаарын үзэгдэл, аэродромын бүсийн нислэг үйлдэх заавар, онцгой тохиолдол, нөхцөл, эрэн хайх, авран туслах төлөвлөгөө;
 3/ ойртолтын ажиглалтын, ойртолтын нарийвчлалтай радар болон бүсийн ажиглалтын удирдлагын зэрэглэл: энэ хэсгийн 2/-т заасан шаардлагыг хангасан байх ба олгогдсон эрхэд хамаарах мэдлэгийн түвшингээ дараах нэмэлт сэдвүүдээр шалгуулна:
 3.1. ажиглалтын болон бусад хяналтын тоног төхөөрөмж, системийн ашиглалт, түүнд тавигдах хязгаарлалт, үндсэн зарчмууд;
 3.2. ойртолтын, нарийвчлалтай ойртолтын, эсхүл бүсийн ажиглалтын удирдлагын үйлчилгээний журмууд.

(b) НХҮ-ний багшлах зэрэглэлтэй этгээдийн шууд удирдлаган дор ажиллаж, дараах туршлагыг хуримтлуулсан байна:
 1/ аэродромын нислэгийн удирдлагын зэрэглэл горилочг

-Зохиож нэмж оруулсан

болон нэмэлт зөвшөөрөл олгосон огноог энэ зүйлийн (а)-д шаардсан мэдэгдлийн дагуу оруулж, тухайн зэрэглэлд зөвшөөрөл олгоно.

(с) Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх эзэмшигч нь Даргад хүсэлт гаргаж, зохих төлбөрийн баримтыг хүргүүлж, олгосон зэрэглэлийг баталгаажуулсан тэмдэглэлийг үнэмлэхэндээ нэмж хийлгэж болно.

үнэмлэх эзэмшигчийн хувьд аэродромын НХУ-ын үйлчилгээг 90-ээс доошгүй цаг, эсхүл 1 сарын хугацаагаар гүйцэтгэсэн байх;

2/ ойртолтын, ойртолтын ажиглалтын удирдлагын, бүсийн болон бүсийн ажиглалтын удирдлагын зэрэглэл горилогч үнэмлэх эзэмшигчийн хувьдшаардагдах ажлын байранд аэродромын, бүсийн НХУ-ын үйлчилгээг 180-аас доошгүй цаг, эсхүл 3 сарын хугацаагаар гүйцэтгэсэн байх;

3/ ойртолтын нарийвчлалтай радар-удирдлагын зэрэглэл авахад 200–аас доошгүй удаагийн нарийвчлалтай ойртолтыг удирдсан, үүний 100-аас дээшгүйг нь ИНЕГ-ын даргын зөвшөөрсөн радарын дадлагажуур дээр гүйцэтгэсэн, мөн 50–иас доошгүйг нь тухайн зэрэглэлээр үйл ажиллагаанд оролцож болох нэгж болон тоног төхөөрөмж дээр гүйцэтгэсэн байх.

(в) Ойртолтын ажиглалтын удирдлагын зэрэглэлээр эдлэх эрх нь ойртолтын радар-удирдлагын үүргийг хамрах бол, 25-аас доошгүй PPI (plan position indicator)-ыг тухайн тоног төхөөрөмжийг ашиглаж байгаа, тухайн зэрэглэлээр үйл ажиллагаанд оролцож болох нэгж дээр зохих зэрэглэлтэй НУ-ийн удирдлага дор гүйцэтгэсэн байна.

(г) Энэ зүйлийн (б) хэсэгт заасан сэдвээр дараах байгууллагаас зохион байгуулсан сургалт дадлагад хамрагдсан байна:

1/ ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн, тухайн төрлийн сургалт дадлага явуулах эрх олгогдсон эсхүл ИНЕГ-аас хүлээн зөвшөөрөгдсөн Иргэний нисэхийн сургалтын байгууллага;

2/ ИНД-172-ын дагуу гэрчилгээжсэн, тухайн төрлийн сургалт дадлага явуулах эрх олгогдсон байгууллага.

(д) ИНЕГ-ын шалгах эрх бүхий этгээдэд НХУ-ыг аюулгүй, шуурхай гүйцэтгэх, нөхцөл байдалд үнэлгээ өгөх ур чадвараа ажлын байран дээр шалгуулсан байна.

<p>65.307 Эрх, хязгаарлалт</p> <p>(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл нь түүнийг эзэмшигчид дараах эрхийг хэрэгжүүлэх эрх олгоно:</p> <p>(1) аэродромын удирдлагын зэрэглэл: тухайн зэрэглэлд зөвшөөрсөн аэродромд, эсхүл аэродромуудад аэродромын удирдлагын үйлчилгээ үзүүлэх;</p> <p>(2) ойртолтын процедур-удирдлагын зэрэглэл: тухайн зэрэглэлд зөвшөөрсөн аэродромд, эсхүл аэродромуудад ойртолтын удирдлагын үйлчилгээ үзүүлэх;</p> <p>(3) ойртолтын ажиглалтын-удирдлагын зэрэглэл: хамааралтай НХУ-ний ажиглалтын системийг ашиглан, тухайн зэрэглэлд зөвшөөрсөн аэродромд, эсхүл аэродромуудад ойртолтын удирдлагын үйлчилгээ үзүүлэх;</p> <p>(4) бүсийн процедур-удирдлагын зэрэглэл: тухайн зэрэглэлд зөвшөөрсөн хяналттай бүс, эсхүл бүсүүдэд бүсийн удирдлагын үйлчилгээ үзүүлэх:</p> <p>(5) бүсийн ажиглалтын-удирдлагын зэрэглэл: хамааралтай ажиглалтын системийг ашиглан, тухайн зэрэглэлд зөвшөөрсөн хяналттай бүс, эсхүл бүсүүдэд бүсийн удирдлагын үйлчилгээ үзүүлэх.</p> <p>(b) Эзэмшигч нь, зэрэглэлийн эрхээ хэрэгжүүлж эхлэхийн өмнө, тухайн зэрэглэлтэй холбоотой хүчинтэй бүх мэдээлэлтэй танилцсан байх үүрэгтэй.</p>	<p>65.307. Эрх, хязгаарлалт</p> <p>(a) Үнэмлэх эзэмшигч нь тогтоогдсон зэрэглэлийн дагуу ажиллах эрхтэй.</p> <p>(б) НУ-ийн зэрэглэл тус бүр нь дараах эрх, үүргийг тодорхойлно:</p> <p>1/ Аэродромын нислэгийн удирдлагын зэрэглэл нь үйлчилгээ явагдах аэродромд НХУ-ын үйлчилгээ үзүүлэх, түүнд хяналт тавих;</p> <p>2/ Ойртолтын нислэгийн удирдлагын зэрэглэл нь үйлчилгээ явагдах аэродром(ууд)-ын ойртолтын НХУ-ын үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих;</p> <p>3/ Бүсийн нислэгийн удирдлагын зэрэглэл нь тогтоогдсон хяналттай агаарын зай буюу агаарын замын дагуу НХУ-ын үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих;</p> <p>4/ Ойртолтын ажиглалтын удирдлагын зэрэглэл нь ойртолтын НХУ-ын үйлчилгээ үзүүлэх нэгжийн хариуцлагын дор тухайн аэродром(ууд)-ын хариуцлагын бүсэд бодит ажиглалтын систем ашиглан НХУ-ын үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих;</p> <p>5/ Ойртолтын нарийвчлалтай радар-удирдлагын зэрэглэл нь тухайн аэродромын хөдөлгөөнд нарийвчлалтай ойртолтын радар-удирдлагын үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих;</p> <p>6/ Бүсийн ажиглалтын удирдлагын зэрэглэл нь тогтоогдсон хяналттай агаарын зай буюу агаарын замын дагуу бодит ажиглалтын тоног төхөөрөмжийн тусламжтайгаар НХУ-ын үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих.</p> <p>(в) Үнэмлэх эзэмшигч нь олгогдсон зэрэглэлийн дагуу үүрэг гүйцэтгэж эхлэхийн өмнө холбогдох бүх бодит мэдээлэлтэй танилцсан байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>65.309 Туршлага хадгалах шаардлага</p> <p>(a) Энэ Дүрмийн дагуу олгосон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн эрхийг нэг ээлжийн үйл ажиллагааны үеэр 5-аас доошгүй цаг, өмнө үргэлжилсэн 28 өдрийн дотор шууд хяналтан дор хэрэгжүүлээгүй бол, эзэмшигч нь тухайн зэрэглэл, эсхүл</p>	<p>65.309. Дадлага, туршлагад тавигдах шаардлага</p>	<p>-“10-аас доошгүй цаг” гэснийг “5-аас доошгүй цаг” гэж өөрчлөгдсөн</p>

<p>зөвшөөрлийн эрхийг дахин хэрэгжүүлэхийн өмнө, бие даан үүрэг гүйцэтгэх чадвараа НХУ-ний багшид шалгуулсан байна.</p> <p>(b) Энэ Дүрмийн дагуу олгосон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн эрхийг өмнө үргэлжилсэн 6 сарын хугацаанд хэрэгжүүлээгүй бол, эзэмшигч нь тухайн зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн эрхийг дахин хэрэгжүүлэхийн өмнө 65.303-ын (a)(4) болон (5)-ын шаардлагыг хангасан байна.</p>	<p>(a) Энэ дүрмийн 65.305 хэсэгт заасан дадлага туршлагыг өргөдөл гаргахаас өмнөх 6 сарын хугацаанд эзэмшсэн байна.</p> <p>(б) Зэрэглэл тогтоогдсон үнэмлэх эзэмшигч нь энэ дүрмийн дагуу олгосон зэрэглэлийн дагуу тухайн ажлын байранд сард 10-аас доошгүй цаг ажилласан, эсхүл дадлагажуурт дадлага хийж ур чадвараа хадгалах ба сүүлийн 21 хоногт олгогдсон зэрэглэлийн дагуу үүрэг гүйцэтгээгүй бол бие дааж ажиллах чадвараа дахин шалгуулна.</p> <p>(в) Зэрэглэл тогтоогдсон үнэмлэх эзэмшигч нь энэ дүрмийн дагуу олгосон зэрэглэлийн дагуу тухайн ажлын байранд сүүлийн 6 сар үүрэг гүйцэтгээгүй бол бие даан ажиллахын өмнө энэ дүрмийн 65.305-ын шаардлагыг хангана.</p> <p>(г) Зэрэглэл тогтоогдсон үнэмлэх эзэмшигч нь жилд нэгээс доошгүй удаа сэргээх, давтан болон онцгой тохиолдолын сургалтанд хамрагдсан байна.</p>	
	<p>65.311. Зэрэглэлийн хүчин төгөлдөр байдал</p> <p>(a) Зэрэглэл тогтоогдсон үнэмлэх эзэмшигч нь НУ-ийн зэрэглэлээр олгогдсон эрхээ тасралтгүй үргэлжилсэн 6 сарын турш хэрэгжүүлээгүй тохиолдолд ИНЕГ-ын дарга тухайн зэрэглэлийг хүчингүйд тооцно.</p> <p>(б) НХУ-ийн зэрэглэл эзэмшигч нь зэрэглэлийн хүчинтэй хугацаа дуусахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө зэрэглэл баталгаажуулах хүсэлтийг ИНЕГ-065/02 маягтын дагуу гаргана.</p>	-зохиомол
	<p>65.313. Нислэгийн удирдагчийн давхар зэрэглэл олгох</p> <p>(a) НУ-ийн давхар зэрэглэл авахаар өргөдөл гаргасан тохиолдолд, ИНЕГ-ын дарга нь зэрэглэл тус бүрийн шаардлагад тулгуурласан зохих шаардлагыг шинээр тодорхойлно.</p>	-зохиомол
Н Бүлэг - Нислэгийн мэдээллийн ажилтны зэрэглэл	3 БҮЛЭГ. НИСЛЭГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТНЫ	

	ЗЭРЭГЛЭЛ	
<p>65.351 Хамрах хүрээ Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) НМА-ны дараах зэрэглэл олгох: (i) аэродромын нислэгийн мэдээллийн зэрэглэл; (ii) бүсийн нислэгийн мэдээллийн зэрэглэл; (2) тухайн зэрэглэлийн эрх хязгаарлалт.</p>	<p>2001 онд орхигдуулсан</p>	<p>-Орхигдуулсан</p>
<p>65.353 Нөхцөл хангах шаардлага НМА-ны зэрэглэл болон тухайн <u>зэрэглэлийн эхний зөвшөөрөл, эсхүл нэмэлт зөвшөөрөл авах этгээд нь</u> дараах шаардлагыг хангасан байна: (1) хүчинтэй НМА-ны үнэмлэх эзэмшдэг байх; (2) дараах байгууллагын зохион байгуулсан, тухайн зэрэглэлтэй холбоотой сургалтын курсийг амжилттай <u>дүүргэсэн</u> байх: (i) ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг <u>зохион байгуулахыг</u> зөвшөөрдөг бол; <u>эсхүл</u> (ii) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол; (3) НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшигчид, зэрэглэл авахаар зорьж байгаа нэгж дээр нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ур чадвар, нөхцөл байдлыг зөв тодорхойлох болон гүйцэтгэх чадвараа шалгуулсан байх.</p>	<p>65.353. Зэрэглэл авахад тавигдах шаардлага (a) Нислэгийн мэдээллийн ажилтны <u>зэрэглэл авах, баталгаажуулах, давхар зэрэглэл авахаар өргөдөл гаргагч нь</u> дараах шаардлагыг хангасан байна: 1/ нислэгийн мэдээллийн ажилтны хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх; 2/ ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн, эсхүл ИНЕГ-аас хүлээн зөвшөөрөгдсөн Иргэний нисэхийн сургалтын байгууллагыг амжилттай <u>төгссөн</u> байх, 3/ ИНД-172-ын дагуу гэрчилгээжсэн, тухайн төрлийн сургалт дадлага <u>явуулах</u> эрх олгогдсон байгууллага. 4/ Нислэгийн мэдээллийн ажилтны зэрэглэл горилогч үнэмлэх эзэмшигчийн хувьд багшлах зэрэглэлтэй этгээдийн удирдлаган дор нислэгийн мэдээллийн үйлчилгээг 80-ээс доошгүй цаг, эсхүл 2 сарын хугацаагаар гүйцэтгэсэн байх; 5/ ИНЕГ-ын шалгах эрх бүхий этгээдэд ажил үйлчилгээ явуулах болон нөхцөл байдалд үнэлгээ өгөх чадвар, тухайн зэрэглэлд хамаарах нэгж дээр нислэгийн мэдээллийн үйлчилгээ явуулах ур чадвараа шалгуулсан байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>65.355 Зэрэглэл олгох <u>(a) НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшигч нь НМА-ны зэрэглэлд тавих 65.353-ын шаардлага хангагдсан гэж үзвэл НМА-ны зэрэглэл олгож, бүртгэлийн дэвтэрт нь тухайн зэрэглэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой нөхцөл, зөвшөөрсөн байрлалын нэр, багшийн нэр, үнэмлэх</u></p>	<p>65.355. Зэрэглэл (a) Энэ дүрмийн дагуу Нислэгийн мэдээллийн ажилтны дараах зэрэглэлийг олгоно. Үүнд: 1/ Аэродромын нислэгийн мэдээллийн; 2/ Бүсийн нислэгийн мэдээллийн.</p>	<p>-Орхигдуулсан</p>

зэрэглэлийн дугаар, гарын үсэг, зэрэглэл олгосон огноо болон дараах мэдэгдлийг оруулна:

[нислэгийн мэдээллийн ажилтны нэр] нь Иргэний нисэхийн дүрэм 65-д заасан нислэгийн мэдээллийн ажилтны дор дурдсан зэрэглэлийн шаардлагыг хангасан болохыг тодорхойлов...

(b) НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшигч нь НМА-ны зэрэглэлийн нэмэлт зөвшөөрөлд тавих 65.353-ын шаардлага хангагдсан гэж үзвэл НМА-ны бүртгэлийн дэвтэрт зэрэглэлийг зөвшөөрсөн байрлалын нэр; багшийн нэр, үнэмлэх зэрэглэлийн дугаар, гарын үсэг болон зэрэглэл олгосон огноог зэрэглэл баталгаажуулах мэдэгдлийн дагуу оруулж, тухайн зэрэглэлд зөвшөөрөл олгоно.

(c) НМА-ны үнэмлэх эзэмшигч нь Даргад хүсэлт гаргаж зохих төлбөрийн баримтыг хүргүүлж зөвшөөрөгдсөн зэрэглэлээ баталгаажуулсан тэмдэглэлийг үнэмлэхэндээ нэмж хийлгэж болно.

65.357 Эрх, хязгаарлалт

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, НМА-ны зэрэглэл нь түүнийг эзэмшигчид дараах эрхийг олгоно:

(1) аэродромын нислэгийн мэдээллийн зэрэглэл: тухайн зэрэглэл эзэмшигчид зөвшөөрсөн аэродром, эсхүл аэродромуудад аэродромын нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх;

(2) бүсийн нислэгийн мэдээллийн зэрэглэл: тухайн зэрэглэл эзэмшигчид зөвшөөрсөн бүс, эсхүл бүсүүдэд нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх.

(b) Эзэмшигч нь зэрэглэлийн эрхээ хэрэгжүүлэхийн өмнө, тухайн зэрэглэлтэй холбоотой бүх хүчинтэй мэдээлэлтэй танилцсан байна.

65.359 Туршлага хадгалах шаардлага

(a) Энэ Дүрмийн дагуу олгосон НМА-ны зэрэглэл, эсхүл

65.357. Эрх, хязгаарлалт

(a) Нислэгийн мэдээллийн ажилтны зэрэглэл нь дараах эрх, үүргийг тодорхойлно:

1/ Аэродромын нислэгийн мэдээллийн зэрэглэлтэй үнэмлэх эзэмшигчийн хувьд, нислэгийн мэдээллийн үйлчилгээгээр хангагдах аэродромын бүсэд нислэгийн мэдээллийн үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой эрх, үүргийг хэрэгжүүлэх;

2/ Бүсийн нислэгийн мэдээллийн зэрэглэлтэй үнэмлэх эзэмшигчийн хувьд түүнд зөвшөөрөгдсөн бүс(үүд)-эд нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой эрх үүргийг хэрэгжүүлэх.

(б) Бүсийн нислэгийн мэдээллийн зэрэглэл бүхий ажилтан нь энэ зүйлийн (а) хэсгийн 1-д заасан аэродромын бүсэд эрх үүргийг хэрэгжүүлэх эрхтэй.

65.359. Дадлага, туршлагад тавигдах шаардлага

(a) Зэрэглэл тогтоогдсон үнэмлэх эзэмшигч нь энэ дүрмийн

-Орчуулга,
найруулга зассан

-Орчуулга найруулга
зассан

<p>зөвшөөрлийн эрхийг нэг ээлжийн үйл ажиллагааны үеэр 5-аас доошгүй цаг, өмнө үргэлжилсэн 28 өдрийн дотор шууд хяналтан дор хэрэгжүүлээгүй бол, эзэмшигч нь тухайн зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн эрхийг дахин хэрэгжүүлэхийн өмнө, бие даан үүрэг гүйцэтгэх чадвараа НХҮ-ний багшид шалгуулсан байна.</p> <p>(b) Энэ Дүрмийн дагуу олгосон НМА-ны зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн эрхийг өмнө үргэлжилсэн 6 сарын хугацаанд хэрэгжүүлээгүй бол, эзэмшигч нь тухайн зэрэглэл, эсхүл зөвшөөрлийн эрхийг дахин хэрэгжүүлэхийн өмнө 65.353-ын (3)-ын шаардлагыг хангасан байна.</p>	<p>дагуу зэрэглэл тогтоолгосноос хойш тухайн ажлын байранд сүүлийн 28 хоногт үүрэг гүйцэтгээгүй бол бие дааж үүрэг гүйцэтгэх чадвараа дахин шалгуулна.</p> <p>(б) Зэрэглэл тогтоогдсон үнэмлэх эзэмшигч нь тухайн зэрэглэлийг тогтоолгосноос хойш ажлын байранд 6 сар үүрэг гүйцэтгээгүй бол бие дааж ажиллахын өмнө энэ дүрмийн 65.353-ын (а) хэсгийн 3-т заасан шаардлагыг хангасан байна.</p>	
<p>I Бүлэг — НХҮ-ний багшийн зэрэглэл</p>	<p>И БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГШЛАХ ЗЭРЭГЛЭЛ</p>	
<p>65.401 Хамрах хүрээ Энэ Бүлэг нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) НХҮ-ний Багшийн зэрэглэл олгох; (2) тухайн зэрэглэлийн эрх хязгаарлалт.</p>		<p>-Орхигдуулсан</p>
<p>65.403 Нөхцөл хангах шаардлага (a) НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмших этгээд нь дараах шаардлагыг хангасан байна: (1) НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшдэг байх; (2) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх, эсхүл НМА-ны үнэмлэхний эрхийг 5-аас доошгүй жил хэрэгжүүлсэн туршлагатай байх; (3) дараах байгууллагын зохион байгуулсан онол болон практикийн зааварчилгаа өгөх сургалтын курсийг амжилттай дүүргэсэн байх: (i) ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол; эсхүл (ii) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн, хэрэв гэрчилгээ</p>	<p>65.403. Зэрэглэл авахад тавигдах шаардлага (a) НХҮ-ний багшийн зэрэглэл тогтоолгохоор өргөдөл гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна: 1/ НХҮ-ний ажилтны хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх; 2/ нисэхийн англи хэлний ур чадварын 4-р түвшинг хангасан байх; 3/ нислэгийн удирдагчийн үүргийг 8-аас доошгүй түүнээс нэг ажлын байранд 4-с доошгүй жил гүйцэтгэсэн байх; 4/ Зохих сургалтанд хамрагдаж амжилттай төгссөн байх; 5/ ИНЕГ-ын шалгах эрх бүхий этгээдэд онол, дадлагаа шалгуулахын хамт тухайн зэрэглэлд заасан эрх, үүргийг гүйцэтгэх ур чадвараа харуулсан байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-“4-с доошгүй жил” гэснийг “5-аас доошгүй жил” гэж өөрчлөгдсөн</p> <p>Орхигдуулсан</p>

нь эзэмшигчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол;

(4) Даргын хүлээн зөвшөөрөхүйц шалгалт болон практик тестийг амжилттай өгч тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэх чадвараа харуулсан байх.

(b) Энэ зүйлийн (a)(4)-т шаардсан шалгалт болон тестийг дараах байгууллага авна:

(1) *ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн үнэлгээ хийхийг зөвшөөрдөг бол; эсхүл*

(2) *ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн үнэлгээ хийхийг зөвшөөрдөг бол.*

(c) Энэ Дүрэм хүчинтэй болохоос өмнө 65.405-д заасантай дүйцэх эрхийг хэрэгжүүлж байсан этгээдийг энэ зүйлийн (a)-ийн нөхцөл хангах шаардлагыг хангасанд тооцно.

65.405 Эрх, хязгаарлалт

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, НХҮ-ний Багшийн зэрэглэл эзэмшигч нь дараах эрхтэй:

(1) НХҮ-ний ажилтанд зааварчилгаа өгөх;

(2) сургалтад хамрагдаж байгаа, эсхүл эрхээ сэргээж байгаа НХҮ-ний ажилтны үүрэг гүйцэтгэж байгаа этгээдэд шууд хяналт тавих;

(3) үнэлгээ хийж, НХҮ-ний зэрэглэл болон зөвшөөрөл олгох.

(b) Энэ зүйлийн (c)-г харгалзан, НХҮ-ний багшийн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэх эзэмшигч нь:

(1) холбогдох үйлчилгээнд хамаарах хүчинтэй зэрэглэл болон зөвшөөрөлтэй хүчинтэй НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшдэг байна;

(2) тухайн эрхийг дараах гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагад хэрэгжүүлнэ:

(i) ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн эрхийг хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг бол; эсхүл

(ii) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн эрх хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг

(б) Энэ зүйлийн (a) хэсгийн 4/-т заасан шалгалтыг дараах байгууллага авна:

1/ ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн, тухайн төрлийн сургалт дадлага явуулах эрх олгогдсон, эсхүл ИНЕГ-аас хүлээн зөвшөөрөгдсөн Иргэний нисэхийн сургалтын байгууллага;

2/ ИНД-172-ын дагуу гэрчилгээжсэн, тухайн төрлийн сургалт дадлага явуулах эрх олгогдсон байгууллага.

65.405. Эрх, хязгаарлалт

(a) НХҮ-ний багшлах зэрэглэл тогтоогдсон үнэмлэх эзэмшигч нь дараах эрхүүдийг хэрэгжүүлнэ:

1/ **Сурагч** нислэгийн удирдагчид багшлах;

2/ сургалтанд хамрагдсан нислэгийн хөдөлгөөний ажилтан болон эрхээ сэргээх зорилгоор НХҮ гүйцэтгэж буй ажилтанд багшлах;

3/ НХҮ-ний зэрэглэл авах этгээдэд **багшлах.**

(б) НХҮ-ний багшлах зэрэглэл тогтоогдсон үнэмлэх эзэмшигч нь НХҮ-ний аливаа эрхээ хэрэгжүүлэхдээ:

1/ НХҮ үзүүлэхэд шаардагдах хүчин төгөлдөр үнэмлэх, зэрэглэлтэй байна;

2/ Энэ зүйлийн (a) хэсэгт заагдсан эрхийг хэрэгжүүлэхдээ ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн Иргэний нисэхийн сургалтын байгууллага, эсхүл ИНД-172-ын дагуу гэрчилгээжсэн НХҮ-ний байгууллагын шууд удирдлагад ажиллана.

3/ НХҮ-ний зэрэглэл тогтоолгох этгээдэд багшлахын тулд

-Орчуулга, найруулга зассан

<p>бол;</p> <p>(3) НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшигчид үнэлгээ хийх, зэрэглэл болон зөвшөөрөл олгохын тулд дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(i) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэхний, эсхүл НМА-ны үнэмлэхний эрхийг 5-аас доошгүй жил хэрэгжүүлсэн туршлагатай байх;</p> <p>(ii) өмнө үргэлжилсэн 13 сарын хугацаанд <u>НХҮ-ний шалгагчийн зэрэглэл эзэмшигчид</u>, тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэх ур чадвараа шалгалтаар болон тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэх үйл явцад суурилсан практик тестээр шалгуулсан байх.</p> <p>(c) <u>НХҮ-ний багшийн зэрэглэл эзэмшигч нь НХҮ үзүүлэх эрхээ хэрэгжүүлээгүй бол, тухайн эзэмшигчийг хүчинтэй ЭМГ-тэй байхыг шаардахгүй.</u></p>	<p>өмнөх 13 сарын хугацаанд ИНЕГ-ын шалгах эрх бүхий этгээдэд холбогдох шалгалтыг өгч, дадлагаа шалгуулахын хамт тухайн эрхийг хэрэгжүүлэх ур чадвараа харуулсан байна.</p>	<p>-Орхигдуулсан</p>
<p>Ж Бүлэг-НХҮ-ний <u>шалгагчийн</u> зэрэглэл</p>	<p>К БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ <u>ШАЛГАХ</u> ЗЭРЭГЛЭЛ</p>	
<p>65.451 Хамрах хүрээ Энэ Бүлэг нь дараах <u>зохицуулалтын</u> шаардлагыг тогтооно:</p> <p>(1) НХҮ-ний шалгагчийн зэрэглэл олгох;</p> <p>(2) тухайн зэрэглэлийн эрх, хязгаарлалт.</p>		<p>-Орхигдуулсан</p>
<p>65.453 Нөхцөл хангах шаардлага (a) НХҮ-ний шалгагчийн зэрэглэл эзэмших <u>этгээд нь</u> дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(1) НХҮ-ний ажилтны үнэмлэх эзэмшдэг байх;</p> <p>(2) нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэхний, эсхүл НМА-ны үнэмлэхний эрхийг <u>8-аас</u> доошгүй жил хэрэгжүүлсэн туршлагатай байх;</p> <p>(3) ИНЕГ-ын шалгах эрх бүхий этгээдэд НХҮ-ний шалгагчийн үүрэг гүйцэтгэх чадвараа шалгуулсан байх.</p> <p>(b) Энэ Дүрэм хүчинтэй болох үед 65.455-д заасантай дүйцэх эрхийг хэрэгжүүлж байсан этгээдийг энэ зүйлийн (a)-ийн <u>нөхцөл хангах</u> шаардлагыг хангасанд тооцно.</p>	<p>65.453. Зэрэглэл авахад тавигдах шаардлага (a) НХҮ-ний шалгах зэрэглэл авахаар <u>өргөдөл гаргагч нь</u> дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ Нислэгийн удирдагчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх;</p> <p>2/ Нислэгийн удирдагчийн үүргийг <u>10-аас</u> доошгүй жил гүйцэтгэсэн байх;</p> <p>3/ Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний тухайн зэрэглэлээр багшлах зэрэглэлээр <u>3-с доошгүй жил</u> ажилласан;</p> <p>4/ Ажлын байр болон дадлагажуур дээр сургалт явуулах, үзүүлэн материал ашиглан зааварчлага өгөх чадвартай;</p> <p>5/ ИНЕГ-ын шалгах эрх бүхий этгээдэд шалгах үүрэг гүйцэтгэх чадвараа шалгуулсан байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-“10-аас доошгүй жил” гэснийг “8 –аас доошгүй жил” гэж өөрчлөгдсөн</p>
<p>65.455 Эрх, хязгаарлалт (a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, НХҮ-ний шалгагчийн</p>	<p>65.455. Эрх, хязгаарлалт (a) НХҮ-ний шалгах зэрэглэл тогтоогдсон үнэмлэх эзэмшигч</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>зэрэглэл эзэмшигч нь дараах эрхтэй:</p> <p>(1) НХҮ-ний ажилтны үнэмлэх олгох, эсхүл эрх сунгах бичгийн, аман болон практик шалгалт авах;</p> <p>(2) <u>НХҮ-ний Багшийн зэрэглэл олгох, эсхүл түүний хүчинтэй байдлыг сунгах бичгийн, аман болон практик шалгалт авах.</u></p> <p>(b) Энэ зүйлийн (c)-г харгалзан, НХҮ-ний шалгагчийн зэрэглэлийн эрх хэрэгжүүлэх эзэмшигч нь:</p> <p>(1) холбогдох үйлчилгээний зэрэглэлтэй хүчинтэй НХҮ-ний <u>ажилтны</u> үнэмлэх эзэмшдэг байна;</p> <p>(2) <u>тухайн шалгалтыг дараах гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагад авна:</u></p> <p>(i) ИНД-172-ын дагуу олгосон НХҮ-ний байгууллагын гэрчилгээ, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн шалгалт авахыг зөвшөөрдөг бол; эсхүл</p> <p>(ii) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ, хэрэв гэрчилгээ нь эзэмшигчид тухайн шалгалт авахыг зөвшөөрдөг бол;</p> <p>(3) өмнө үргэлжилсэн <u>13 сарын хугацаанд</u>, ИНЕГ-ын шалгах эрх бүхий этгээдэд НХҮ-ний шалгагчийн үүрэг гүйцэтгэх чадвараа шалгуулсан байна.</p> <p>(c) НХҮ-ний шалгагчийн зэрэглэл эзэмшигч нь НХҮ үзүүлэх эрхээ хэрэгжүүлээгүй бол, тухайн эзэмшигчийг хүчинтэй ЭМГ-тэй байхыг шаардахгүй.</p>	<p>нь дараах эрхтэй:</p> <p>1/ НҮ-ийн зэрэглэл олгох, эрх сэргээх, баталгаажуулах зорилго бүхий дадлагыг шалгах, <u>дүгнэлт гаргах.</u></p> <p>(б) НХҮ-ний шалгах зэрэглэл тогтоогдсон үнэмлэх эзэмшигч нь НХҮ-нд оролцохдоо:</p> <p>1/ Холбогдох зэрэглэл бүхий хүчин төгөлдөр НХҮ-ний үнэмлэхтэй байна;</p> <p>2/ ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн Иргэний нисэхийн сургалтын байгууллагын хүрээнд , эсхүл ИНД-172-ын дагуу гэрчилгээжсэн НХҮ-ний байгууллагын хүрээнд шалгалт авах эрхтэй байна.</p> <p>3/ ИНЕГ-ын шалгах эрх бүхий этгээдэд холбогдох шалгалтыг өгч, дадлагаа шалгуулахын хамт шалгах эрх, үүргийг хэрэгжүүлэх ур чадвараа харуулна.</p> <p>(в) Шалгах зэрэглэл тогтоогдсон үнэмлэх эзэмшигч нь НХҮ-нд шууд оролцохгүй тохиолдолд эрүүл мэндийн гэрчилгээ <u>эзэмших</u> шаардлагагүй.</p>	<p>-Орхигдуулсан</p>
	<p>ХАВСРАЛТ А. АНГЛИ ХЭЛНИЙ ТҮВШИНД ТАВИГДАХ ШААРДЛАГА</p>	<p>-АС65-1-д тусгагдсан</p>

Дүрмийн боловсруулалтын хэлтэс

ХАВСРАЛТ А. АНГЛИ ХЭЛНИЙ ТҮВШИНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Түвшин	Дуудлага	Бүтэц	Үсгийн сан	Ярих чадвар	Ойлгох чадвар	Бусдад ойлгуулах чадвар
Мэргэшсэн 6	Эх хэл, эсхүл бүс нутгийн онцлог нь дуудлага, өргөлт, хэмнэл болон аялгад бага зэргийн нөлөөлсөн ч энэ нь харилцагч ярьж байгаа зүйлийг нь ойлгоход огт нөлөөлөхгүй.	Энгийн болон хавсарсан нийлмэл өгүүлбэрийн хувьд хэл зүйн дүрмийн зөв зохион байгуулалттай	Мэддэг, мэддэггүй аливаа сэдвээр ярилцах үгийн сангийн өргөн цар хүрээ болон үгийн сонголттой.	Ямар нэгэн оролдлого гаргахгүйгээр эх хэл шигээ ярьж чаддаг. Өгүүлбэрийн хоорондох холбоос үгийг хар аяндаа зөв, оновчтой ашигладаг.	Хэлний болон соёлын нарийн ялгаануудын талаарх ойлголтуудыг багтаасан бараг бүх хам сэдвүүдийн хүрээнд үнэн зөв ойлгодог.	Бараг бүх нөхцөл байдалд өөрийгөө хялбархан ойлгуулдаг. Аман болон аман бус дохиог амархан ойлгож зохих журмынх нь дагуу зөв хариултыг өгдөг.
Гүнзгийрсэн 5	Эх хэл, эсхүл бүс нутгийн онцлог нь дуудлага, өргөлт, хэмнэл болон аялгад бага зэргийн нөлөөлсөн ч энэ нь харилцагч ярьж байгаа зүйлийг ойлгоход хааяа саад болдог	Энгийн болон хавсарсан нийлмэл өгүүлбэрийн хувьд бүтцийн зөв зохион байгуулалттай. Хавсарсан нийлмэл өгүүлбэрийг бүтээхдээ бага зэргийн утгын алдаа гаргадаг.	Нийтлэг, бодит, ажил төрөлтэй холбоотой сэдвээр холбоо барих үгийн сангийн цар хүрээ болон үгийн сонголттой. Хэвшмэл хэллэгийг оновчтой хэрэглэдэг. Зарим тохиолдолд үгийн сонголт хувийн шинжтэй байдаг.	Өөрийн мэддэг сэдвийн хүрээнд чөлөөтэй ярьдаг ч нийтлэг хүрээнд бол үгүй. Өгүүлбэрийн хоорондох холбоос үгийг зөв, оновчтой ашигладаг	Үйл явдал бодож байснаас өөрөөр эргэх, мөн хэлний, эсхүл нөхцөл байдлын төвөгтэй байдал учрахад нийтлэг, бодит, ажил төрөлтэй холбоотой сэдэв дээр төвөггүй ойлгож ярилцдаг.	Хариултыг хурдан, зохих журмын дагуу өгдөг. Ярилцагч/ сонсогчтой үнэн зөв харилцдаг.
Дээд шат 4	Эх хэл, эсхүл бүс нутгийн онцлог нь дуудлага, өргөлт, хэмнэл болон аялгад нөлөөлсөн ч энэ нь харилцагч ярьж байгаа зүйлийг ойлгоход үе үе саад болдог	Энгийн болон хавсарсан нийлмэл өгүүлбэрийн хувьд бүтцийн зөв зохион байгуулалттай. Зарим тохиолдолд, тухайлбал санаандгүй нөхцөл байдал учрахад бага зэргийн утгын алдаа гаргадаг	Нийтлэг, бодит, ажил төрөлтэй холбоотой сэдвээр холбоо барих үгийн сангийн цар хүрээ болон үгийн сонголттой. Гэнэтийн болоод санаандгүй байдалд үгийн сан дутагдахад хэвшмэл хэллэгийг оновчтой зөв хэрэглэж чаддаг	Тодорхой хэмнэлтэйгээр яриаг сунжруулдаг. Давтах, эсхүл нэг хэвийн ярианаас аяндаа шилжихэд түгдрэхгүй, ярих байдал бага зэрэг алдагддаг ч энэ нь харилцаа холбоо тогтооход саад болдоггүй. Зарим тохиолдолд өгүүлбэрийн хоорондох холбоос үгийг зөв ашигладаг	Тодорхой, илт аялга, дуудлагатай үйлчлүүлэгчтэй харилцах тохиолдолд нийтлэг, бодит, ажил төрлийн холбоотой сэдвийн ихэнх хэсгийг тодорхой ойлгодог. Ярилцагч хэл, нөхцөл байдлын бэрхшээлтэй учрах тохиолдолд түүнийг бага зэрэг удаж ойлгох, эсхүл тодруулга шаарддаг.	Хариултыг хурдан, зохих журмынх нь дагуу өгдөг. Үйл явдал бодож байснаас өөрөөр эргэх тохиолдолд өөр үгийг орлуулан хэрэглэдэг. Буруу ойлголцсон нь илэрхий болмогц нэн даруй хянаж, бататган, тодруулах замаар зөв болгож чаддаг
Дунд шат 3	Эх хэл, эсхүл бүс нутгийн онцлог нь дуудлага, өргөлт, хэмнэл болон аялгад нөлөөлсөн ба энэ нь харилцагч ярьж байгаа зүйлийг ойлгоход дахин дахин саад болдог.	Нөхцөл байдлын талаар урьдчилан хэлчихээд байхад энгийн болон хавсарсан нийлмэл өгүүлбэрийн бүтцийн зохион байгуулалт дээр ямагт алдаа гаргадаг. Утгын алдаа байнга гаргаж байдаг.	Нийтлэг, бодит, ажил төрөлтэй холбоотой сэдвээр холбоо барих үгийн сангийн цар хүрээ болон үгийн сонголттой ч байнга үгийн сан нь дутагдаж үг сонголтыг буруу хийдэг. Үгсийн сан дутагдах үед хэвшмэл үгийг оновчтой хэрэглэж чаддаггүй.	Яриаг сунжруулан, хэллэг пауз хоёрыг зохицуулж чаддаггүй. Ярианы явцад гарах саатал, эсхүл удах байдал нь харилцаа холбоо тогтооход саад болдог.	Тодорхой илт аялга, дуудлагатай үйлчлүүлэгчтэй харилцах тохиолдолд нийтлэг, бодит, ажил төрлийн холбоотой сэдвийг тодорхой ойлгодог. Үйл явдал бодож байснаас өөрөөр эргэх, мөн хэл болон нөхцөл байдлын бэрхшээл тулгарах үед ойлгох чадвар дутагддаг.	Хариултыг зарим тохиолдолд хурдан, журмын дагуу өгдөг. Ямар нэг урьдчилсан нөхцөл байдал болон өөрийн мэдэж байгаа сэдэв дээр харилцан яриаг эхлүүлэх болон үргэжлүүлэхдээ сайн. Ерөнхийдээ үйл явдал бодож байснаас өөрөөр эргэх тохиолдолд харилцан яриаг хан-галттай хийж чаддаггүй.
Анхан шат 2	Эх хэл, эсхүл бүс нутгийн онцлог нь дуудлага, өргөлт, хэмнэл болон аялгад нөлөөлсөн ба энэ нь харилцагч ярьж байгаа зүйлийг ойлгоход байнга саад болдог.	Байнга хэрэглэгдэж байдаг өгүүлбэрийг л зөв хэрэглэдэг	Зөвхөн дан ганц утгыг илэрхийлсэн үгс, мөн цээжилсэн хэвшмэл хэллэгүүдээс бүрдсэн үгийн сантай	Мэдэж байгаа цөөн хэдэн үгээрээ харилцан ярих бөгөөд хэлэх гэж байгаа утгаа гүйцэд гаргаж чаддаггүй.	Хэдийгээр аажуухан, анхаарал-тай үгээ хэлэн ярилцах боловч ганцхан утга, мөн цээжилсэн хэвшмэл хэллэгийнхээ хүрээнд ойлгож чадна.	Эргээд маш их удаан хэрнээ оновчгүй хариул-тыг өгдөг. Харилцан яриа зөвхөн энгийн үгийн хүрээнд болж өнгөрдөг.
Анхан шатны өмнөх үе 1	Анхан түвшингээс доогуур түвшинтэй	Анхан түвшингээс доогуур түвшинтэй	Анхан түвшингээс доогуур түвшинтэй	Анхан түвшингээс доогуур түвшинтэй	Анхан түвшингээс доогуур түвшинтэй	Анхан түвшингээс доогуур түвшинтэй